

ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ
ТОГТВОРТОЙ БИЧИЛ УУРХАЙ ТӨСӨЛ

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН
НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН
СУУРЬ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ХӨГЖЛИЙН ЭЗЭД ТББ

7/24/2009-09/05/2009

ГАРЧИГ

Бүлэг 1	
Удиртгал	6
Нэгдсэн дүгнэлт буюу судалгааны үр дүнд гарч ирсэн гол мэдээлэлүүд	7-8
Бүлэг 2. Танилцуулга	
2.1. Ерөнхий мэдээлэл	10
2.2. Судалгааны гол зорилго, аргачлал, түүвэрлэлт	10-12
Бүлэг 3. Баянхонгор аймгийн Жаргалант сумын өнөөгийн нөхцөл байдал	
3.1. Газар зүйн байрлал, байгалийн нөөцийн талаарх үндсэн мэдээлэл	14
3.2 Хүн ам зүйн байдал	14-15
3.3. Гэрлэлт, гэр бүлийн байдал	16
3.4. Бичиг үсэг тайлгадалт, боловсролын байдал	17
3.5. Орон нутгийн харьяалал, шилжилт хөдөлгөөний талаарх мэдээлэл	17-18
Бүлэг 4. ХАМО иргэдийн алт олборлолтын орлого ба зардал	
4.1. Алт олборлолтын хэмжээ, мөнгөн дүн	20
4.2. Алт олборлохдоо гаргадаг зардалын байдал	20-21
4.3. Алт олборлолтын үйл ажиллагааны эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, Монгол Банк, дэлхийн зах зээлийн үнийн харьцуулалт	21-22
4.4. Төлбөрийн чадвар буюу сэтгэл ханамж	22
Бүлэг 5. Жаргалант сумын хувиараа алт олборлогч иргэдийн амьжиргааны талаарх мэдээлэл	
5.1. Амьдарч буй ахуй нөхцөл байдал	24
5.2. Хөдөлмөр эрхлэлт буюу сургуульд суралцах байдал	24
5.3. ХАМО иргэдийн өрхийн орлогын байдал	25-26
5.4. ХАМО нарын МАА эрхлэлтийн байдал	27
5.5 ХАМО нарын тээврийн хэрэгсэл эзэмших байдал	27
5.6. Өрхийн сарын зардлын хэмжээ болон сард үүсгэдэг хуримтлалын хэмжээ	27-28
Бүлэг 6. Алт олборлолт буюу ажил эрхлэлтийн байдал	
6.1. ХАМО иргэдийн дундахь алт олборлолт, уламжлалт МАА эрхлэлтийн талаарх харьцуулсан ойлголт	30
6.2. Алт олборлох болсон шалтгаан, гол бэрхшээлүүд	30-32
6.3. Зөвшөөрөлтэй газар үйл ажиллагаа явуулж байгаа байдал	32
6.4. ХАМО нарын ажлын ачаалал, амралт чөлөөт цагийн байдал	33
6.5. ХАМО нарын хөдөлмөрийн хуваарилалт, хүндрэл	34
6.6 ХАМО иргэдийн хөдөлмөрийн багаж хэрэгслийн байдал, тэдгээрийн хүчин чадал, бүтээмж	34-35
Бүлэг 7. ХАМО иргэдийн эрүүл мэндийн байдал болон эрүүл мэндийн үйлчилгээг хэрхэн авч байгаа талаар	
7.1. Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжтэй байдал	37
7.2. ХАМО иргэдийн ажлын байрны нөхцөл байдал болон эрүүл мэндийн байдал	38
7.3. ХАМО иргэдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тохиолддог ажлын	39-40

осол аваарууд, тэдгээрийн шалтгаан	
7.4 ХАМО иргэдийн ЭМД, НД, ХАОАТ-ын төлөлтийн байдал, мэдээлэл, мэдлэг	40-41
Бүлэг 8. ХАМО иргэдийн зохион байгуулалт, хамтын ажиллагаа	
8.1. ХАМО иргэдийн дундах нөхөрлөлийн зохион байгуулалт	43
8.2 Байдрагийн Хөгжил ТББ-ийн үйл ажиллагааны талаарх ХАМО иргэдийн санал, үнэлэмж	44
8.3.ХАМО иргэдийн хамгийн их хэрэгцээтэй байгаа зүйл	45
Бүлэг 9. Дүгнэлт	48
Бүлэг 10. Санал, зөвлөмж	50-51
Хавсралтууд	53-79

ТОВЧИЛСОН ҮГС

ААН	Аж Ахуйн Нэгж
МАА	Мал Аж Ахуй
ХАОАТ	Хүн Амын Орлогын Албан татвар
ЭМД	Эрүүл Мэндийн Даатгал
НД	Нийгмийн Даатгал
ХАМО	Хувиараа Ашигт Малтмал Олборлогч
ТӨБҮТ	Тогтвортой Бичил Уурхай Төсөл
БХТББ	Байдрагийн хөгжил ТББ
НХХЯ	Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Яам
ХААДОТ	Хүн амын амьжиргааны доод түвшин
ТББ	Төрийн Бус Байгууллага
УУАА	Уул Уурхайн Аврах Алба
БОЯ	Байгаль Орчны Яам
УИХ	Улсын Их Хурал
УСҮГ	Улсын Статистикийн Үндэсний Газар

ХҮСНЭГТИЙН ТАЙЛБАР

- Хүснэгт 1.1** ХАМО нарын ядуурал, газар эзэмшил, осол аваарын түвшин
- Хүснэгт 1.2** ХАМО нарын эрх зүй, зохицуулалтын орчин дахь хэрэгжилт
- Хүснэгт 1.3** ХАМО нарын бүтэц зохион байгуулалтад хамрагдалтын хувь
- Хүснэгт 1.4** ХАМО нарын орлогын хэмжээ
- Хүснэгт 1.5** ХАМО нарын нөхөн сэргээлт, гэмт хэрэг зөрчлийн хувь
- Хүснэгт 3.1** ХАМО нарын нас хүйсийн ангилал
- Хүснэгт 3.2** Өрхийн ам бүлийн тооны байдал
- Хүснэгт 3.3** Орон нутгийн харьяалал, шилжилт хөдөлгөөн
- Хүснэгт 4.1** ХАМО нарын алт олборлолтын хэмжээ, мөнгөн дүн
- Хүснэгт 4.2** ХАМО иргэдийн алт олборлоходоо гаргадаг зардалын байдал

- Хүснэгт 4.3** ХАМО нарын алт олборлолтын үйл ажиллагааны эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд
- Хүснэгт 6.1** ХАМО иргэдийн тухайн уурхайнуудад ажилласан хугацаа
- Хүснэгт 6.2** ХАМО иргэдийн ажил, амралтын горим
- Хүснэгт 6.3** ХАМО нарын ихэвчлэн ажилладаг улирал, эзлэх хувиар
- Хүснэгт 8.1** ТББ-ын ХАМО нарт явуулдаг үйл ажиллагаа, эзлэх хувиар

ЗУРГИЙН ТАЙЛБАР

- Зураг 3.1** Нас хүйсийн суварга
- Зураг 3.2** ХАМО нарын боловсролын түвшин, хүйсээр
- Зураг 4.1** 1 ХАМО иргэний алт олборлоходо гаргадаг зардал улиралаар
- Зураг 4.2** Нийт ХАМО иргэдийн алт олборлоходо гаргадаг зардалын улиралаар
- Зураг 4.3** Монголбанк, дэлхийн зах зээл, ХАМО иргэдийн 1 унц алтны үнийн харьцуулалт
- Зураг 5.1** ХАМО нарын давхар ажил эрхлэлтийн байдал
- Зураг 5.2** ХАМО нарын сарын дундаж орлогын хэмжээ эх үүсвэр бүрээр
- Зураг 5.3** ХАМО нарын сарын орлогын эх үүсвэрүүд эзлэх хувиар
- Зураг 5.4** Сумын нэг хүнд оногдох өрхийн орлогын хэмжээ
- Зураг 6.1** Алт олборлолт, МАА эрхлэх талаар ХАМО нарын бодол
- Зураг 6.2** Алт олборлох болсон шалтгаан
- Зураг 6.3** Алт олборлох үед тохиолддог бэрхшээлүүд, хувийн жин
- Зураг 6.4** ХАМО иргэдийн ажлын хуваарь, хүйсээр
- Зураг 6.5** ХАМО иргэдийн хөдөлмөрийг хөнгөвчилдэг хэрэгсэл, хувиар
- Зураг 7.1** Эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах байдал
- Зураг 7.2** ХАМО нарын өвчлөлийн байдал хувиар
- Зураг 7.3** Осол аваарын шалтгаан
- Зураг 7.4** ХАМО нарын татвар, шимтгэл төлөлтийн харьцуулалт
- Зураг 7.5** ХАОАТ төлдөггүй шалтгаан
- Зураг 8.1** Нөхөрлөлийн талаар сонссон эсэх
- Зураг 8.2** Нөхөрлөлд орохын давуу тал
- Зураг 8.3** ХАМО иргэдийн хамгийн их хэрэгцээтэй байгаа зүйл
- Зураг 8.4** ХАМО нарын эрх ашгийг хамгаалдаг байгуулага

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

1 унц – 31,1035 грамм

1 лан – 37,5 грамм

1 цэн – 3,75 грамм

1фун – 0,375 грамм

Явуулын ХАМО - богино хугацаагар алт олборлодог ХАМО

Суурин ХАМО – 6 сараас дээш хугацаагаар байнга оршин сууж алт олборлодог ХАМО

БҮЛЭГ 1

УДИРТГАЛ

УДИРТГАЛ

Монгол улсын эдийн засгийн голлох салбар уул уурхай, түүний дотор алт олборлох үйлдвэрлэл нь 1990-ээд оны үеэс Монгол улсын Засгийн газрын “Алт” хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш эрчимтэй хөгжиж улс орны валютын нөөцийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлсэн билээ.

Уул уурхайн компаниуд олноор байгуулагдаж, алтны лиценз зөвшөөрлүүд их хэмжээгээр олгогдон, гадны хөрөнгө оруулалтууд энэ салбарт нэмэгдсэнтэй зэрэгцэн хувиараа ашигт малтмал олборлогч иргэд ч мөн адил алт олборлож эхэлсэн. Хөдөө орон нутагт жил дараалан байгаль, цаг уурын хүндрэлтэй байдлаас малчид их хэмжээгээр малаа алдсан, мөн жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ дорвитой хөгжөөгүй, ажилгүйдэл, ядуурлын түвшин буурахгүй байгаагаас хувиараа ашигт малтмал олборлогч иргэд улам бүр нэмэгдсээр байна.

Төр засгийн зүгээс энэ өсөн нэмэгдэж буй иргэдийн үйл ажиллагааг зохион байгуулалтанд оруулах, хариуцлагыг өндөржүүлэх, тэдгээрийн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр өнгөрсөн оноос “Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр”, “Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ыг гарган мөрдүүлж байна.

Эдгээр үйл ажиллагааны хүрээнд Швейцарийн Хөгжлийн Агентлагын Тогтвортой Бичил Уурхай Төслийн захиалгаар Баянхонгор аймгийн Жаргалант сумын нийгэм-эдийн засгийн суурь судалгааг Хөгжлийн Эзэд ТББ-ын судалгааны баг хийж гүйцэтгэлээ.

Энэхүү судалгааг Баянхонгор аймгийн Жаргалант сумын Баруун, Зүүн салаа болон Анаг гэдэг газруудад хувиараа ашигт малтмал олборлож байсан иргэдээс тоон болон чанарын судалгааны аргыг ашиглан судалгаа авлаа. Судалгааны тохиромжтой арга зүй, техникуүдийг ашиглан тэдгээр иргэдийн нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, орлогын түвшин, хөдөлмөр эрхлэлт, аюулгүй үйл ажиллагааны нөхцөл, эрүүл мэнд, нийгмийн хамгаалалтанд хамрагдах байдал зэрэг нөхцөл байдлыг тодорхойлон гаргахыг зорьлоо.

Судалгааны үр дүнг ашиглан “Тогтвортой бичил уурхай төсөл”-ийн хамт олон Баянхонгор аймгийн Жаргалант сумын хувиараа ашигт малтмал олборлон амьдарч байгаа иргэдийн өнөөгийн нийгэм эдийн засгийн байдлыг бодитойгоор мэдэж, цаашдын үйл ажиллагаагаа төлөвлөх, төслийн үр дүнг тооцох зэрэг үйл ажиллагаанд ашиглаж болох юм.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ БЮОУ СУДАЛГААНЫ ҮР ДҮНД ГАРЧ ИРСЭН ГОЛ МЭДЭЭЛЛҮҮД

Судалгааны багийнхан Жаргалант сумын нийгэм эдийн засгийн байдлыг тодорхойлох судалгааг хийх судалгааны үндсэн арга зүй болох холбогдох бичиг баримтуудыг уншиж танилцаж байх явцдаа төслийн зорилго, зорилтууд гаргахыг эрмэлзэж буй үр дүнгүүдтэй сайтар танилцсан дараахь товч мэдээлэл, дүгнэлтийг гаргалаа.

ТөБУТөслийн зорилго: ТөБУТ нь Монгол улсад хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэхэд холбогдох талуудтай хамтран ажиллаж, бичил уурхай эрхлэгчдийг хөдөөгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах эдийн засгийн дэд салбарын хариуцлагатай гишүүд болгоход хувь нэмэр оруулах болно.

Төслийн зорилготой холбоотой дараахь үндсэн нөхцөл байдал төсөл хэрэгжүүлж буй орон нутагт байна хэмээн судалгаагаар гарч ирлээ. Үүнд:

Үзүүлэлт	Хувь
Ядуурлын түвшин	70,4%
ХАМО нарын газар эзэмшлийн байдал	94.1%
ХАМО нарын дунд гарч байгаа осол аваарын байдал	10.3%

Одийн 1.1

Үр дүн - 1: Бичил уурхайн салбарт ил тод, шударга бодлого эрх зүй, зохицуулалтын орчин бүрдүүлж, хэрэгжилтийг эхлүүлсэн байх

Үзүүлэлт	Хувь
Албан ёсны зөвшөөрөлтэй газар дээр алт олборлолт, боловсруулалт хийж байгаа ХАМО иргэдийн эзлэх хувь	91.5%

Нийгмийн даатгалын шимтгэлээ төлдөг ХАМО иргэдийн эзлэх хувь	37,4%
Хүн амын орлогын албан татвараа төлж байгаа ХАМО иргэдийн эзлэх хувь	4%
Эрүүл мэндийн даатгалаа төлсөн ХАМО иргэдийн тоо	84,2%

Үр дүн - 2: Бичил уурхайн бүх түвшинд бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг сайжруулсан байх

Үзүүлэлт	Хувь	Тайлбар
ХАМО нарын эрхийг хамгаалахын төлөө ажилладаг үндэсний хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг бусад талуудад хүлээн зөвшөөрөгдсөн ХАМО нарын үндэсний хэмжээн дэхь бүтэц	0	Оролцогч нар ТоБУТ-ийг энэ үүргийг гүйцэтгэж байна гэж хэлж байлаа.
ТББ-ын үйл ажиллагааг мэддэг ХАМО иргэдийн эзлэх хувь	92%	
Үндэсний болон орон нутгийн хэмжээнд ХАМО нарын өмнө тулгамдаад байгаа асуудлуудыг хөндөж, шийдүүлсэн байдал	1 асуудал	Газрын асуудлыг ТоБУТ, БХ ТББ-ын оролцоотойгоор шийдүүлсэн байна
Нөхөрлөлийн зохион байгуулалтад орсон ХАМО иргэдийн эзлэх хувь	78,3%	

Одийн 1.3

Үр дүн - 3: Бичил уурхай эрхлэгчдийг үр ашигтай хариуцлагатай бичил уурхай болон бусад бизнесийн үйл ажиллагааг эрхлэх чадвартай болгоход нь дэмжлэг үзүүлэх

Үзүүлэлт	Хувь		
ХАМО нарын алт олборлох үйл ажиллагаатай холбоотой гарч байгаа осол аваарын тоо (жилээр)	10.3%		
ХАМО нарын олборлож буй алтны хэмжээ /грамм/	Өдөр	Долоо хоног	Сар
	0,5	1,5-2,5	7-10
ХАМО нарын сарын дундаж орлого	16000төг	48000-80000төг	231000 төг

Үр дүн-4: Бичил уурхай эрхлэгчид ба бусад нөөц ашиглагчдыг байгаль экологи, нийгмийн асуудалд хариуцлагатай хандаж, гарч буй зөрчлийг шийдэж чаддаг чадвартай болгох

Нооцын төрөлтийн орчны өвлийн

Үзүүлэлт	Хувь
ХАМО наартай холбоотой гарч байгаа гэмт хэрэг зөрчлүүдийн эзлэх хувь (жилээр)	Мэдээлэл байхгүй
Нөхөн сэргээлт хийсэн газрын хэмжээ	5-6 га

Өрнүүдэл 1.5



БҮЛЭГ 2

ТАНИЛЦУУЛГА

2.1. Баянхонгор аймгийн талаарх төвч мэдээлэл

Баянхонгор аймаг нь Сибирийн их тайгаас төв Азийн говь цөлд шилжих бүсэд Монгол улсын нутаг дэвсгэрийн баруун төв хэсэгт байрлаж, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Завхан, Архангай аймгуудтай нутаг залган БНХАУ-тай 140 км нутгаар хиллэсэн, 116 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай. Монгол улсын нутаг дэвсгэрийн 7.8 хувийг эзэлдэг томоохон аймгийн нэг юм. Аймгийн төв Баянхонгор хот нь Улаанбаатар хотоос 630 км зайдай оршдог.

Засаг захиргааны нэгжийн хувьд 20 сүм, 101 баг, Шаргалжуут хэмээх 1 тосгонтой. 2009 оны эхний хагасын байдлаар Баянхонгор аймаг нь 22412 өрх, 82205 хүн амтай байна.

Ихэнх нутаг нь далайн түвшнээс дээш 1000-1400 м өргөгдсөн боловч хамгийн нам дор газар болох Эхийн гол 720 м, хамгийн өндөр Их Богд уул 3957 метрт өргөгдсөн юм. Агаарын температур нь хүйтний улиралд дунджаар 18-30 хэм хүйтэн, дулааны улиралд 15-27 хэм дулаан байдаг.

Нутгийн хойд хэсгээр 62,2 мянган га хар модон, өмнөд хэсгээрээ 477,0 мянган га заган ойтой. Тус аймаг алт, зэс, хар, хүрэн нүүрс, болор, жонш, гялтгануур гантиг, боржин, шөрмөс чулуу зэрэг ашигт малтмал, төрөл бүрийн шороон будаг, сайн чанарын шавар, шохойн чулуу гэх мэт барилгын материал нэн элбэгтэй.

Аймгийн эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй бөгөөд 2008 оны эцэст 2643,5 мянган толгой мал тоолуулсны 27,4 мянга нь тэмээ, 916 мянга нь адuu, 1224 мянга нь үхэр, 705,2 мянга нь хонь, 695,9 мянга нь ямаа байна.

Хайгуулын зөвшөөрөлтэй 229 ААН, ашиглалтын 60 ААН байгаагаас 2003 оноос хойш энэ тоо буурч 6 байгууллага ашиглалт явуулж байна.

2.2. Судалгааны зорилго, зорилтууд

Баянхонгор аймгийн Жаргалант сумын нийгэм эдийн засгийн нөхцөл байдлыг судлах, тус суманд хувиараа ашигт малтмал олборлож буй иргэдийн үйл ажиллагаа, тэдний алтнаас олж байгаа орлого нь тухайн орон нутгийн эдийн засгийн хөгжилд хэр зэрэг хувь нэмэр оруулж байгаа болон байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг судлах

Судалгааны зорилтууд:

1. Сонгогдсон газар хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн нийгэм эдийн засгийн бүтэц зохион байгуулалт, байгаль орчинд нөлөөлж буй хүчин зүйлийг судлах
2. Хувиараа алт олборлож буй иргэдийн жилд олборлож буй алтны хэмжээг тодорхойлох
3. Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн алтаа борлуулж байгаа зах зээл, борлуулж буй үнэ ханшиг олж тодруулах.
4. Хувиараа ашигт малтмал олборлож буй иргэдийн сум орон нутгынхаа нийгэм эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг олж судлах
5. Хувиараа ашигт малтмал олборлож буй иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох
6. Хувиараа ашигт малтмал олборлож буй иргэдийн эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал, химиин хорт бодис хэрэглэж байгаа эсэхийг судлах
7. Хувиараа ашигт малтмал олборлож буй иргэд хэрхэн, ямар бүтэц зохион байгуулалтанд байдаг эсэхийг олж мэдэх
8. Хувиараа ашигт малтмал олборлож буй иргэдийн олборлосон алтнаас олж буй орлого, алтны олборлолтын хэмжээг тодорхойлох
9. Хувиараа ашигт малтмал олборлож буй иргэдийн давуу талуудыг олж мэдэх

2.3. Судалгааны аргачлал

Судалгааны удирдамжийн дагуу шаардлагатай мэдээллийг цуглуулахын тулд тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан ашигласан юм. Судалгаанд дараахь арга зүйг ашигласан болно. Үүнд:

- Хоёрдогч мэдээллийн эх сурвалж болон статистик мэдээллүүдийг уншиж танилцах
- Асуулгын арга
- Бүлгийн ярилцлагын арга
- Гүнзгийрүүлсэн ярилцлагын арга
- Кейс судалгааны арга
- Ажиглалтын арга

2.4. Судалгааны түүвэрлэлт

ТоБУТөслөөс судалгаанд хамруулахаар санал болгосон Баянхонгор аймгийн Жаргалант сумын нийт иргэдийг түүврийн ерөнхий хүрээ гэж тооцон энгийн санамсаргүй түүврийн зарчмаар судалгаанд оролцогчийг (иргэн) сонгосон болно. Хувиараа ашигт малтмал олборлогсдын бодит тоог улирлын хэлбэлзэл, онцлог зэргээс шалтгаалан гаргахад хүндрэлтэй байдгийг харгалзан 95 хувийн түвшинд 5.0 хувийн алдааны магадлалтайгаар байхаар тооцон Жаргалант сумын Зүүн салаа, Баруун салаа болон Анаг хэмээх газруудаас 200 хувиараа алт олборлогчдийг түүвэрлэн судлахад тохиromжтой гэж үзлээ.

Хувиараа ашигт малтмал олборлогсдын асуумж судалгаанд хувиараа ашигт малтмал олборлож буй 200 иргэнийг сонгосон ба 91,5 хувь буюу 183 хүн нь Жаргалантын Баруун болон Зүүн салаанд алт олборлож байсан бол 8,5 хувь буюу 17 хүн нь Анагт алт олборлож байсан болно.

2.5. Мэдээллийн шинжилгээ

Тоон судалгааны мэдээллийг оруулж, үр дүнгийн шинжилгээ хийн, мэдээлэл боловсруулахад **SPSS –16** программ хангамжийг ашиглав.

2.6. Судалгааны явцад тохиолдсон бэрхшээл

- ХАМО иргэдийн дунд өрхийн орлого зарлагаа урьд нь тооцож үзээгүй улмаас орлого зарлагаа тодорхойлоход нэлээд цаг хугацаа зарцуулж байсан.
- Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь эрэгтэйчүүд байсан нь өрхийн нарийн тооцоо, зарцуулалтын талаарх мэдээлэл гаргаж өгөхдөө тааруу байв.
- Судалгаа авах үед тухайн Баянхонгор аймагт Баруун бүсийн Ламын гэгээний ойн даншиг наадам болоод удаагүй байсан учраас ХАМО иргэд наадмаас буцаж ирэх хүртэл хүлээж бага зэрэг хугацаа алдсан болно.
- Өрхийн орлого, зарлага зэрэг нь тухайн өрхийн хувийн чанартай асуулга байсан учраас зарим судалгаанд оролцогчид мэдээлэл өгөхдөө өмзэглэх, буруугаар ойлгох тохиолдол гарч байсан.
- ХАМО иргэд нь алт олборлож буй газрынхаа хэмжээг сайн хэлж мэдэхгүй энэ нь тэдэнд тодорхойгүй, ойлгомжгүй байгаа нь ажиглагдсан.



БҮЛЭГЗ

ЖАРГАЛАНТ СУМЫН ГАЗАР ЗҮЙН БАЙРЛАЛ, ХҮН АМ ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Жаргалант суманд хувиараа алт олборлон амьдарч байгаа иргэдийн нас хүйсийн бүтэц, гэрлэлтийн байдал, ам бүлийн тоо, боловсролын түвшин зэргийг судлан шинжилж энэ төрлийн ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн дундах онцлог болон нийтлэг байдлыг энэ бүлгээр дамжуулан харуулах болно. Энэхүү судалгааг Жаргалант сумын Баруун, Зүүн салаа хэмээх Монгол Алт компанийн ашиглаад нөхөн сэргээлт хийсэн газар болон Анагийн хөндий хэмээх шороон орд газруудад алт олборлож байсан хувиараа алт олборлогч иргэдийн дунд хийсэн юм.

3.1. Жаргалант сумын өнөөгийн нөхцөл байдал

Жаргалант сум нь Архангай аймгийн Хангай, Чулуут сум, аймгийнхаа Галуут, Бөмбөгөр, Заг, Гурванбулаг гэсэн дөрвөн сумтай хиллэн оршдог. Баянхонгор аймгийн төвөөс 180км, Улаанбаатар хотоос 930 км алслагдсан сум юм. Жаргалант сум нь далайн түвшнээс дээш 2130 метр өндөрт байрладаг. Хамгийн өндөр цэг Түжил хайрхан 3257 метр өндөр юм. Хангай Хэнтийн уулархаг бүс нутагт хамарагддаг нутгийн хэмжээ 414318 га болно.

Ойн сан бүхий газарт хар мод, бургас, балгана, хуш зэрэг мод голлон ургадаг. Байнга оршдог ан амьтан нь буга, янгири ямаа, хүдэр, зэрлэг гахай, ирвэс, шилүүс, чоно, үнэг, хярс, тарвага булган суусар, загас, шувууд нь шонхор, харцага, бор галуу, хун, ангир, тогоруу, нугас, шар шувуу, сар, элээ зэрэг болно.

Олгой нуур, Давсан нуур, Өртөн, Тээл зэрэг том, жижиг олон нууртай. Хамгийн том Хөх нуурын урт нь 7 км, өргөн нь 2,5-3 км болно. Байдрагийн гол, Цохиотын гол, Мандалын гол, Хүрэм, Цагаан дөрөлж, Хөх даваа, Улаан чулуут, Баруун зүүн, дунд гээд олонтой голууд цэвэр усны нөөцтэй.


Мөн Жаргалант сум нь алтны нөөц ихтэй, зэс, мөнгө, төмрийн илэрц ихтэй, хүрмэн чулуугаар баялаг нутаг юм. Мөн давсан нууртай бөгөөд тус нуурнаас жилд 100-200 тонныг олборлох бололцоотой гэж нутгийн хүмүүс ярьж байлаа.

3.2. Хүн ам зүйн шинж байдал

Жаргалант сумын Баруун, Зүүн салааны шороон орд газарт зүн намрын улиралд буюу оргил үедээ 450- 500 гаруй хувиараа алт олборлогч иргэд ирж алт олборлодог бөгөөд одоогоор 5 дахь жилдээ энэ газрыг ашиглаж байгаа юм байна. 2009 оны 7-8 сарын байдлаар тус сумын нийт өрхийн 80 гаруй хувийн хэн нэгэн төлөөлөл алт олборлож өрхийн амьжиргаандaa хувь нэмэр оруулж байсан бөгөөд тэдний 8.5 хувь нь Анагт, 91.5 хувь нь Баруун, Зүүн салаанаа алт олборлож байлаа.

Судалгаанд нийт хамрагдсан ХАМО иргэдийн 65.5% нь эрэгтэй, 34.5% эмэгтэй байсан ба хүйсийн харьцаа 1 эмэгтэй тутам 1.9 эрэгтэй ноогдож байна. Энэ нь хувиараа алт олборлох ажил нь харьцангуй хүнд нөхцөлтэй учир эрэгтэйчүүдийн оролцоо давамгай байгаатай холбоотой юм.

Судалгаанд оролцогчдын нас , хүйсний суварга
Үүдээсээ
Үүдээсээ



Соёолаа 3.1

Нас хүйсийн бүтцийн суврагаас харахад эрэгтэйчүүдийн хувьд 36-45 нас, эмэгтэйчүүдийн хувьд 26-35 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин харьцангуй их болох нь харагдаж байна. Алт олборлож байгаа эрэгтэйчүүдийн насны бүтцэд шинжилгээ хийвэл 26-35 насны идэр залуу насныхан 23.5% эзэлж байгаа бөгөөд 35-45 насныхан 26%-ийг эзэлж байна. Үүнээс харахад шороон ордод алт

олборлох нь биеийн хүч шаардсан хүнд хэцүү ажил учир ихэвчлэн залуу хүмүүс ажиллаж байгаа нь харагдаж байна.

Сонгогдсон үзүүлэлт	Зүүн салаа	Анаа
Хүйс		
Эрэгтэй	65.5	82.0
Эмэгтэй	34.5	18.0
Насны бүлэг		
16-18	9.00	12.0
19-25	16.0	29.0
26-35	26.0	24.0
36-45	23.5	6.0
46-55	18.5	11.0
56-65	7.00	17.0
66 ба түүнээс дээш	0.00	0.0
Нийт		
Нийт ХАМО-н тоо	183	17

Óñivão 31

Харин эмэгтэйчүүдийн хувьд 26-35 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин харьцангуй их болох нь харагдаж байна. Үүнийг эмэгтэйчүүдийн дунд хийсэн бүлгийн ярилцлагын явцад олж авсан чанарын мэдээллэтийн харьцуулан үзвэл 26-35 насны эмэгтэйчүүдийн хувьд амьдрахын эрхээр эрэгтэй хүмүүсийн хийдэг бүх ажлуудыг хийж байгаа нь харагдсан юм.

...Бидний насны дээжээ нээг хувьд хөдөө орон нутагт ажил хөдөлмөр эрхлэх боломж бололцоо байхгүй, өдөэгээд нийдэлбэрээдээ дээдээдийн тулд хүйтэнд хөрч, халуунд халж, эрэгтэй хүмүүсээс ялгагдахгүй дээдээд хүнд хүцүү бүхнийг хийж байна. Намайг турганхай болохоор дандаа шруултуулдаг. Харанхуй агааргүй учраас толгой эргэж, ухаан алдаж унах дөхдөг. Осол гарснаас хойши нүхэнд орохоосоо бүр их айж жихүүдэг болсон.

Эмэгтэйчүүдийн бүлгийн ярилцлага У, 20 настай эмэгтэй

3.3. Гэрлэлтийн байдал:

Судалгаанд хамрагдагсдын 68.5% баталгаатай гэр бүлтэй, 23.5% огт гэрлэж байгаагүй, 2.5% бэлэвсэн, 2.5% хамтран амьдардаг, 14% нь гэр бүлээсээ тусдаа амьдарч байгаа хүмүүс байлаа. Жаргалант сумын хувиараа алт олборлогч нарын алт олборлох нь гэр бүлийн бизнес хэлбэрээр хөгжиж байгаа нь тодорхой харагдаж байлаа. Мөн сургалтынхаа төлбөрийг олохоор ирсэн ганц бие оюутан залуучууд мөн зонхилох хувийг эзэлж байлаа.

Өрхийн ам бүлийн тооны байдал

Сонгогдсон үзүүлэлт		Эзлэх %
Ам бүлийн тоо		
1		1.5
2-4		49.5
5-7		37.5
8-10		11.5
Нийт		100
Нийт ХАМО-н тоо		200

Одийн 3.2

Судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 49.5% нь өөрөөсөө гадна 2-3 хүн, 37.5% өөрөөсөө гадна 4-6 хүнийг, 11.5% хувь нь өөрөөсөө гадна 7-9 хүнийг алтнаас олж байгаа орлогоороо тэжээдэг болох нь харагдаж байна.

Эндээс харахад Жаргалант сумын нийт хүн амын 80% нь тогтмол буюу улирлын чанартайгаар алтнаас олж байгаа орлогоороо амьдралаа залгуулж байгаа болох нь нотлогдож байна.

3.4. Бичиг үсэг тайлгадалт, боловсролын байдал

Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 97.0% асуулгад бичиг үсэг тайлгадсан, 3% бичиг үсэг тайлгадаагүй гэж хариулсан байсан нь улсын дунджаас (2008 байдлаар) 1% бага байна. Судалгаанд хамрагдагсдын боловсролын түвшинг нийт хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн хүйсээр харьцуулан Зураг 2.2-т харуулав

Судалгаанд хамрагдсан ХАМО нарын боловсролын түвшин, хүйсээр



Соодлал 3.2

3.5. Орон нутгийн харъяалал, шилжилт хөдөлгөөний талаарх мэдээлэл

Бид хувиараа ашигт малтмал олборлогсдын шилжилт хөдөлгөөнд оролцож буй байдал, тэдгээрийн иргэний бүртгэлийн хамрагдалт, бүртгэлтэй холбоотой асуудлуудыг энэхүү хэсгээр гарган харуулахыг зорьлоо.

Судалгаанд хамрагдсан сумын нутагт ажиллаж буй ХАМО нарын 89.2 хувь нь орон нутгийн угуул иргэд, үлдсэн 10.7% хувь нь шилжин ирэгсэд байлаа.

Сонгогдсон үзүүлэлт	Эзлэх %
Угуул оршин суугч	89.2%
3 дээш жил амьдарч байгаа	5.1%
1-3 жил амьдарч байгаа	1.5%
1 хүртэл жил амьдарч байгаа	4.1%
Нийт	100
Нийт ХАМО-н тоо	200

Одийн 3.3

Иргэд нийгмийн суурь тусlamж үйлчилгээг хүртэхэд иргэний бүртгэлийн бичиг баримтууд зайлшгүй шаардлагатай байдаг. Хувиараа алт олборлогсод иргэний бүртгэлд хамрагдаагүй, бичиг баримтгүйгээс болж ажиллаж буй орон нутгаасаа эрүүл мэнд, нийгмийн тусlamж үйлчилгээг хүртэхэд хүндрэлтэй байдаг.

Хэдийгээр судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь нутгийн угуул оршин суугч иргэд байсан боловч тэдний 11 хувь нь иргэний ямар нэг бичиг баримтгүй иргэд байгаа нь шилжин суурьшигчдаас гадна орон нутагт бүртгэлгүй иргэд нилээд байгааг харуулж байна.

Уурхай дээр алт олборлон амьдарч байгаа иргэдийн 90 гаруй хувь нь гэрт харин 10 гаруй хувь нь найз нөхөд, хамаатныхаа гэрт түр амьдардаг, урц майханд амьдардаг гэж хариулсан байсан бөгөөд тэднийг амьдарч буй байдлаар нь явуулын ба суурин гэж хувааж үзэх боломжтой байна.

“Явуулын” алт олборлогч гэдэг нь сумын төв, тухайн уурхайгаас хол газар амьдардаг хүмүүс өдрөөр, 7 хоног, сараар гэх мэт хугацаагаар ирж ажилладаг ба тухайн газартаа ойр амьдардаг хүмүүс нь өдрийн цагаар ажиллаад оройдоо буцдаг бол холын хүмүүс нь тэнд гэр хөлслөх, таньдаг айлдаа түр амьдрах зэргээр ажилладаг байна. “Суурин” алт олборлогч гэдэгт 6 сараас дээш хугацаатайгаар тухайн уурхайд ажиллаж амьдарч байгаа өөрийн гэр сууцтай иргэдийг хамруулж болох юм.

Энэ нь тэд явуулын байдлаар алт олборлох ажлыг эрхэлж буйгаас бүртгүүлэх сонирхол бага, нөгөө талаас орон нутгийн засаг захиргаа иргэдийг бүртгэлд хамруулах талаар анхаарал тавьдаггүйтэй холбоотой байж болох юм.

Тухайн уурхайн алтны гарц, цаашид ашиглагдах хугацаанаас тэнд ажиллаж буй ХАМО нарын суурьшилт шууд шалтгаалж байна гэсэн дүгнэлт хийж болох юм.

Иргэдээс иргэний бүртгэлд бүртгүүлээгүй байгаа шалтгааныг тодруулахад 37.5% хувь нь бүртгүүлэх шаардлагагүй, 6.3 хувь нь яаж бүртгүүлэхээ мэдэхгүй гэж

хариулжээ. Харин 56.3% нь Улаанбаатар хот болон бусад газар бүртгэлтэй энд түр алт олборлож байна гэжээ.

Шилжин ирэгсэд болон бүртгэлгүй иргэдийн энд ямар шалтгааны улмаас ирсэн бэ? гэсэн асуултанд хариулсан байдлыг шинжилж үзэхэд 89.2 хувь нь алт олборлохын тулд, ажиллаж мөнгө олох боломж хайж гэж хариулсан бөгөөд эндээс харахад Жаргалант сумын хүн амын шилжилт хөдөлгөөнд хамгийн ихээр нөлөөлж буй хүчин зүйлс нь хүмүүсийн байгалийн баялагийг ашиглан амьжиргаагаа залгуулах, улмаар амьдралынхаа чанарыг сайжруулах явдал байгаа нь харагдаж байна.



БҮЛЭГ 4

ХАМО НАРЫН АЛТ ОЛБОРЛОЛТЫН ОРЛОГО БА ЗАРДАЛ

4.1. ХАМО нарын алт олборлолтын хэмжээ, мөнгөн хэмжээ (өдөр, сараар, жилээр)

Энэхүү судалгааны хамгийн чухал хэсэг болох ХАМО иргэдийн орлогын хэмжээг тодорхойлох улмаар тэдний сум орон нутгийн эдийн засгийн хөгжилд ямар хувь нэмэр оруулж байгаа талаар энэхүү бүлэгт өгүүлэх юм. Судалгаанд оролцогч нараас өдөрт хэдий хэмжээний алт олборлодог талаар асуухад оролцсон ХАМО иргэдийн 71.9 хувь нь ойролцоогоор 0.5 грамм буюу 16 000 төгрөг, 12.3 хувь нь 0.75 грамм буюу 24 000 төгрөг олдог гэж хариулсан ба зарим өдөр алт олборлохгүй тохиолдол ч гардаг хэмээн бүгд хариулж байлаа.

ХАМО нар олборлосон алтаа 1 фунг 12 000 төгрөгөөр, 1 цэнг 120 000 төгрөгөөр, 1 лант 1 200 000 төгрөгөөр тус тус борлуулдаг.

Доорхи хүснэгтээс нэг хүний өдөрт, долоо хоног, сард олдог алтны хэмжээг алтны тухайн үеийн дундаж ханшаар тооцон харууллаа.

Сонгогдсон үзүүлэлт	Төгрөг	Хувийн жин	Хүний тоогоор
Өдөрт олборлож буй алтны хэмжээ (грамм)			
0.5- доош	16 000-аас доош	71.9	146
0.5 - 0.75	16 000-24 000	12.3	25
1.0- 1.5	32 000-48 000	5.4	11
1.5-2.0	48 000-64 000	6.4	13
Долоо хоногт олборлож буй алтны хэмжээ (грамм)			

1-ээс доош	32 000-аас доош	5.4	11
1-2 грамм	32 000-64 000	30.5	62
2.2-3.0	70 400-96 000	36.9	75
3.0-4	96 000-128 000	9.4	19
Сард олборлож буй алтны хэмжээ (грамм)			
5-с доош	160 000-аас доош	19.7	40
5.0-10	160 000-320 000	39.4	80
10-15	320 000-480 000	20.2	41
16-20	512 000-640 000	9.4	19


Одийн 4.1

4.2. ХАМО иргэдийн алт олборлохдоо гаргадаг зардалын байдал

Сонгогдсон үзүүлэлт	Хувийн жин	НИЙТ
Өдөрт алт олборлоход зарцуулдаг зардал		
5000-с доош	63.5	129
5001-10.000	29.6	60
10.001-15.000	2.5	5
15.001-20000	1	2
Долоо хоногт алт олборлоход зарцуулдаг зардал		
35.000-с доош	66	138
35.001-45.000	8.4	17
45.001-55.000	2.5	5
55.001-65.000	3.4	7


Одийн 4.2

ХАМО иргэд нэг хүнд ноогдох зардлаараа жилийн 4 улиралын өвөл нь хамгийн өндөр буюу 463,266 төгрөгийн зардал гаргадаг бөгөөд энэ нь хөлдсөн газрыг гэсгээх, зэрэгт ихэвчлэн зарцуулагддаг байна.



Соодлал 4.1


Харин нийт алт олборлох зардлын хувьд зуны улиралд хамгийн өндөр буюу 67,1 сая төгрөгийн зардал гаргадаг байна. Зуны улиралд ХАМО нарын тоо ихэсдэг тул нэгжид ноогдох зардал бага гардаг нь дээрх графикаас харагдаж байна.



Однорийн 4.2

4.3 ХАМО нарын алт олборлолтын үйл ажиллагааны эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, Монгол Банк, дэлхийн зах зээлийн үнийн харьцуулалт

Баянхонгор аймгийн Жаргалант сумын ХАМО нарын 1 унц алтны үнэ 2009 оны 8-р сарын дундаж байдлаар 995 312 төгрөг байсан бол Монголбанкны 1 унц алтны үнэ 1 352 971 төгрөг байлаа. Харин олон улсын зах зээл Блүүмбэргийн сүлжээ дээр 1 унц алтны үнэ 1 373 593 төгрөг байсан байна. Эндээс хэрэв алт худалдан авах үйл ажиллагааг хуулийн хүрээнд зохицуулж чадвал Жаргалант сумын ХАМО нарын алтны орлогын хэмжээ 158 111 250 төгрөгөөр нэмэгдэх боломжтой нь харагдаж байна. Гэхдээ энэ нөхцөлд ХАМО нарын хувьд хууль ёсны бүх татварыг төлөх, алтны сорьцын хэмжээг тогтоох гэх мэтчилэн бусад нэмэлт зардалууд гарах юм.



Содолын 4.3

ХАМО нарын алт олборлолтын үйл ажиллагааны эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд,	Тоо хэмжээ
Жилд олборлодог алтны хэмжээ	13,75 кг
Алтны жилийн орлогын хэмжээ /сая.төг/	440,0
Алт олборлоход гаргадаг жилийн зардлын хэмжээ /сая.төг/	176,4
Жилийн ашгийн хэмжээ /сая.төг/	263,6
Жилийн ашгийн хувь	59%

Однорийн 4.3

4.4 ХАМО нарын төлбөрийн чадвар буюу сэтгэл ханамж

Алтнаас олсон орлогодоо хэр сэтгэл хангалуун байдаг вэ гэсэн асуултанд 63 хувь сэтгэл хангалуун, 34 хувь нь дунд зэрэг 2 хувь нь хангалуун бус гэж хариулсан байлаа. Мөн судалгаанд хамрагсдын 29.1 хувь алтнаас олсон орлогогоосоо бага ч гэсэн хуримтлал үүсгэдэг гэсэн бол үлдсэн 70.9 хувь хуримтлал үүсгэж чаддаггүй гэж хариулсан байлаа.

Судалгаанд хамрагсан ХАМО иргэдээс 23.2 хувь нь өр, зээлтэй гэсэн бол 75.4 хувь нь зээлгүй байсан. Энэхүү мэдээлэл нь тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ХААН банк, Монгол шуудан банкны удирдлага, ажилчидтай хийсэн ганцаарчилсан буюу гүнзгийрүүлсэн ярилцлаганаас гарсан мэдээллүүдээр батлагдаж байлаа. Мөн банкны зээлийн эргэн төлөлтийн хувьд бусад сумуудыг бодвол харьцангуй өндөр байдаг ба үүнийг алт олборлох үйл ажиллагаа, алтны гарцтай шууд хамааралтай байдаг гэж банкны ажилчид ярьж байлаа.

Харин зээлтэй байгаа ХАМО нарыг ямар учраас ззэл авсан талаар тодруулахад 12.3% нь ахуйн хэрэгцээндээ зориулж, 4.4% нь хүүхдийн сургалтын төлбөрт, 2.5% нь эмчилгээнд, 1 хувь нь уулын ажил эрхлэхийн тулд гэж авсан байлаа. Харин олборлосон алтаа хаана борлуулдаг вэ? гэсэн асуултанд 17.7 хувь нь гэр дэлгүүрт, 2.5 хувь нь хот эсвэл аймагт очиж борлуулдаг 78.3 хувь нь газар дээр нь алтны ченжид өгдөг гэж хариулсан байна.



БҮЛЭГ 5

ХАМО ИРГЭДИЙН АМЬЖИРГААНЫ ТҮВШИН БҮЮУ ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАМЖ

5.1. Амьдарч буй ахуй нөхцөл байдал


Орон гэрийн нөхцөл байдлын хувьд судалгаанд оролцсон ХАМО иргэдийн хувьд 81.8% Монгол гэрт, 7.9% байшинд, 7.9% эцэг эхийнхээ гэрт, 1% хувь гэр байшин түрээслэж амьдардаг гэж судалгаанд хариулсан байлаа. Үүнээс харахад Жаргалант суманд ой мод багатай, төвлөрсөн барилгын материалын зах зээлээс харьцангуй хол оршдог учир модон болон барилгын бусад материалаар хийгдсэн байшинд амьдрах нь ховор, голдуу Монгол гэрт амьдардаг болох нь харагдаж байна.

Тэд гэрийг амьдрах, амрах орчин болгохын зэрэгцээ хүн цөөнтэй айлуудын хувьд бусдыг байрлуулах, гэр “хоолны газар”, “дэлгүүр”, “билльярд”, “караоке” зэрэг үйлчилгээний газар болгон ашиглаж байна. Энэ маягаар алт олборлохын зэрэгцээ жижиг бизнес эрхлэн орлого олдог иргэд цөөнгүй байдаг байна. ХАМО иргэдийн хувьд ТоБҮТ төслийн гэр нь кино үзэх, сургалт сурчилгаанд суух, хурал уулзалт зохион байгуулах зэрэг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх гол төв болдог юм байна.

5.2. ХАМО нарын дундахь ажил хөдөлмөр эрхлэлт болон сургуульд суралцах байдал

Жаргалант сумын ХАМО иргэдийн дунд давхар ажил эрхлэлт, сургуульд суралцах байдал их байна. Үүнийг ХАМО нар боловсролоо дээшлүүлж, чөлөөт цагаараа ажил хөдөлмөр эрхэлж байна гэхээсээ илүү төрийн албан хаагч нар, дунд сургуулийн сурагч, их дээд сургуулийн оюутнууд зуны амралтаараа алт олборлон мөнгөн олж амьдрал ахуйдаа хэрэглэх, сургалтын төлбөрөө олж байна гэж байна тайлбарлах нь зүйтэй юм.

Нийт асуулганд хамрагдсан ХАМО нарын 55% сургуульд сурдаг болон давхар ажил хөдөлмөр эрхэлдэг, орлогын өөр эх үүсвэртэй гэж хариулсан байлаа. Давхар эрхлэж байгаа хөдөлмөрийн байдалд нь дүн шинжилгээ хийж үзвэл малчин, төрийн албан хаагч байсан бөгөөд суралцагчдын хувьд оюутнуудаас гадна дунд сургуулийн сурагчид баагүй хувийг эзэлж байлаа. Үүнийг диаграммаар харуулвал:




Сöддä 5.1

Давхар ажил хөдөлмөр эрхэлдэг гэж хариулсан ХАМО иргэдийн 47% мал аж ахуй эрхэлдэг хүмүүс байлаа. Үүнээс харахад өнөөгийн Жаргалант сумын малчдыг малчин-ХАМО хэмээн нэрлэгдэхүйц болсон байна. Харин 23% нь 16-18 насын зуны амралтаараа аав ээждээ тусалж байгаа сурагчид байлаа. 13% нь сургалтын төлбөр, байрны төлбөр, хичээлийн хэрэгсэл, гар утас болон бусад хэрэгцээт зүйлээ худалдан авах мөнгө олохын тулд ажиллаж байгаа оюутнууд байлаа. 8% нь гэр дэлгүүр, гэр гуанз, гэр караоке ажиллуулж, аргал түлээ түүж зардаг иргэд байв. 5% нь Байдрагын Хөгжил төрийн бус байгууллагад сонгуульт ажил эрхэлдэг хүмүүс байсан ба төрийн байгууллага болон улсын байгууллагад ажилладаг хүмүүс тус бүр 2%-ийг эзэлж байлаа. Эндээс харахад тогтмол орлого бүхий ажил эрхлэж байгаа хүмүүс зөвхөн 12% байна. Төрийн байгууллагад ажилладаг хүмүүсийн хувьд эмч сувилагч, орон нутгийн засаг захиргааны байгууллагад ажилладаг хүмүүс байлаа.

5.3. ХАМО иргэдийн өрхийн орлогын байдал

Судалгааны нэгэн чухал зорилгын нэг бол эдийн засгийн идэвхтэй хүн ам бөгөөд орлого олох зорилгоор ажил эрхэлж байгаа ажиллах хүч болох ХАМО нарын

орлого зарлагын түвшинг тодорхойлох замаар тэдний эдийн засгийн чадвар, орон нутгийн эдийн засгийн хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг тодорхойлох явдал байсан юм. Тэдний хийж байгаа ажил хөдөлмөр тус бүрээр нь сарын дундаж орлогын түвшинг тооцон гаргавал дараахь байдалтай байна.



Соодлал 5.2

Сумын төвийн ААН, албан байгууллагад ажил эрхлэгчдийн хувьд сарын дундаж цалин 257,4 мянган төгрөг байсан бөгөөд харин ХАМО иргэдийн хувьд сард дунджаар 231 мянган төгрөг олдог бөгөөд дээд тал нь сард 1.2 сая олдог гэж хариулж байсан юм. ХАМО иргэдийн сарын дундаж орлого нь сумын төвийн ажилтнуудынхаас 11%-иар доогуур байна.




Соодлал 5.3

Гэр худалдаа наймаа, гуанз, баар, кароаке ажиллуулж, билльяард тоглуулах бизнес хийдэг иргэдийн хувьд эрхлэж байгаа бизнесээсээ хамааран сард дунджаар 130 гаруй мянган төгрөгний орлого олдог байна. Харин давхар МАА эрхэлдэг ХАМО нар хариулахдаа малын гаралтай түүхий эдийн үнэ буурч байгаа, мөн МАА-гаас хамаарсан орлого улиралын чанартай, сүү цагаан идээ зарж борлуулах зах зээл байхгүй зэргээс хамааран МАА –гаас орж ирэх орлого бага буюу сард дунджаар 37000 төгрөгний орлого олдог гэж хариулсан байлаа. Бүлгийн ярилцлагад оролцсон иргэд хэлэхдээ:

Бүх юмны үнэ өсч байгаа ч ганцхан МАА гаралтай түүхий эдийн үнэ маш их бууж байна. Одоо ганцхай мал дагаж амьдрах аргагүй болоод байна. Аргаа бараадаа хэдэн малаа хүүхдэдээ даатгачихаад өөрөө энд байж байхав дээ. Алтнаас олсон хэдэн цаас амьдралд их жийрэг болдог, хэрэгтэй байдаг юм.

Эрэгтэйчүүдийн бүлгийн ярилцлага Б, 45 настай эр

Хувиараа алт олборлогч иргэдийн өрхийн нэг хүнд оногдох орлогын байдалд анализ хийж үзэхэд нийт судалгаанд хамрагдагсдын 70.4 хувийн өрхийн нэг хүнд оногдох сарын орлогын хэмжээ Монгол Улсын засгийн газраас тогтоосон амьжиргааны баталгаажих доод түвшнээс доогуур орлоготой байлаа. /ХААДоТ 2009 оны байдлаар Баянхонгор аймагт 90600 төгрөг байхаар УСҮГ-аас тогтоосон/. Жаргалант сумын өрхийн 1 хүнд ноогдох орлогын хэмжээг Зураг 5.4-д харуулав. Жаргалант сумын иргэдийн 10 гаруй хувь нь газар тариалан эрхэлдэг хэдий ч, судалгаанд хамрагдсан ХАМО иргэдийн дунд алт олборлохоос гадна газар тариалан эрхэлдэг иргэд байгаагүй юм. Швейцарийн Хөгжлийн Агентлагын Тогтвортой Бичил Уурхай төслөөс өөр гадаад, дотоодын санхүүжилттэй төсөл хөтөлбөрүүд төдийлөн хэрэгждэггүйгээс иргэдийн дунд өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилготой жижиг бизнес эрхлэх, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтууд явдаггүй учир иргэд МАА, ХАМО үйл ажиллагаанаас өөр өрхийн орлого нэмэгдүүлэх үйл ажиллагаа эрхэлдэггүй байна.



Çöðää 5.4

5.4 ХАМО нарын МАА эрхлэлтийн байдал

ХАМО иргэдийн 51.4% нь МАА эрхэлдэг гэж хариулсан боловч тэдний хариулж, ашиг шимиийн хүртэж байгаа малын тоо толгой нь амьжиргаагаа залгуулах төдий тоо толгойтой байлаа. Тэдний дунд зуугаас дээш толгой хоньтой өрх 1, зуугаас дээш толгой ямаатай өрх 2 байсан бөгөөд зуугаас дээш толгой бод малтай өрхүүд байсангүй.

Мал маллахын зэрэгцээ алт олборлож амьдардаг иргэдийн хувьд голдуу хонь ямаа нийлсэн 100 гаруй бог малтай, 6-10 тооны үхэртэй, 5 орчим тооны уналганы морьтой болох харагдаж байлаа. Эдгээр тоо толгой, бүтэц бүхий сүрэг нь зөвхөн өрхийн хэрэгцээгээ хангах төдий байдаг учир илүү өөр орлогын эх үүсвэрийг хайхаас өөр аргагүй байдаг гэж судалгаанд хамрагдагсад өгүүлж байлаа.

5.5. ХАМО нарын тээврийн хэрэгсэл эзэмших байдал

Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 50.3% нь ямар нэгэн төрлийн өөрөө явагч тээврийн хэрэгсэлтэй гэж хариулсан. Тээврийн хэрэгслийн төрлөөр нь нь ангилан харвал 35.5% нь мотоцикльтой, 18.2% нь суудлын машинтай, 6% нь ачааны машинтай, 1% нь том болон жижиг оврын трактортой гэж хариулсан байлаа. Сумын төвийн хэмжээнд нийт 129 тээврийн хэрэгсэл тоологдсон байна.

5.6. Өрхийн сарын зардлын хэмжээ

Хэдийгээр ХАМО иргэдийн хувьд өрхийн сарын дундаж орлого 250000 – 350000 төгрөг байгаа ч тэдний сарын зардал өрхийн ам бүлийн тоонд харьцуулан үзэхэд тийм ч хангалттай байж чадахгүй байна. Судалгааны хариултаас харахад ХАМО иргэд амьдралынхаа хэвийн үед орлогынхоо 70 гаруй хувийг хоол хүнсэндээ, өр зээлэндээ 12%, хүүхдийн хичээлийн хэрэгсэлд 5% (оюутны сургалтыг төлбөрийг оруулалгүй), эм эмчилгээнд 2%, малын тэжээлд 3%, хувцас 5%, бусад зүйлд 3% зарцуулдаг гэж хариулсан байна.

Олсон хэдэн цаасаа хоол хүнсэндээ хэрэглээд дуусдаг. Зарим алт гаражгүй өдрүүдэд дэлгүүрээс зээлээр хоол хүнсээ авдаг. Тэгээд л жоохон алт олонгуутаа өр, хоол хүнсэндээ өгөөд дуусдаг. Гэхдээ хангай дэлхийнхээ буянд өрөө төлж чадахгүй байх, хоолгүй хоног тохиолдол одоохондоо алга л байна.

Эмэгтэйчүүдийн бүлгийн ярилцлага
53 настай эмэгтэй

Судалгаанд хамрагдсан ХАМО иргэдийн 70,5% олсон орлогоосоо амьдралдаа хэрэгцээтэй зүйлийг худалдан авах, үр хүүхдүүдийнхээ боловсрол, өөрийгөө хөгжүүлэх мөн амьдралд тохиолдож болзошгүй хэцүү нөхцөл байдлууд болох өвчин зовлон, үхэл хагацал зэрэг тохиолдвол хэрэглэх зорилготойгоор мөнгө хадгалах санаа байдаг ч хуримтлал үүсгэж чаддаггүй гэж хариулсан байна. Харин 12,8% нь сард 40000 хүртэл төгрөгний мөнгө хадгалдаг, харин 16,7% нь 40 000 -аас дээш төгрөгний хуримтлал үүсгэдэг гэж хариулсан байна.




БҮЛЭГ 6

АЛТ ОЛБОРЛОЛТ БУЮУ АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

6.1. ХАМО иргэдийн МАА эрхлэлт болон алт олборлолтын талаарх хандлага

Мал аж ахуй эрхлэх, хувиараа алт олборлох талаар хувиараа алт олборлож байгаа иргэдээс тэдний үзэл хандлагыг танадах асуулга асуухад нийт судалгаанд оролцогчдын 54,2 хувь алт олборлох нь ашигтай, харин үлдсэн 44,3% нь мал аж ахуй эрхлэх нь ашигтай хэмээн хариулсан байна.




Соёл 6.1

Ямар шалтгааны улмаас алт олборлох нь илүү ашигтай гэж бодож байгаа талаар лавлахад тогтмол орлогын эх үүсвэр зайлшгүй хэрэгтэй байдаг. Алт нь хөрвөх

чадвар сайтай учир олсон даруйдаа зарж борлуулан хэрэгцээтэй зүйлээ худалдан авахад амар байдаг гэсэн байлаа. Харин тэдний мал аж ахуйг яагаад хувиараа алт ухахаас ашиггүй гэж байгаа талаар тодруулан асуухад малын гаралтай түүхий эдийн үнэ бууж байгаа, сүү цагаан идээ борлуулах зах зээл хязгаарлагдмал, хотод очиж сүү цагаан идээ, мах зарахад зардал ихтэй учир тэр болгон яваад байж чаддагүй зөвхөн ноолуурын үед ноолуураа зарж хэдэн төгрөг олдог бусад үед малынхаяа ашиг шимийг өрхийн хэрэгцээндээ л хэрэглэхээс зарж борлуулж мөнгө болгож чаддагүй учир бэлэн мөнгөний хомсдолд байнга ордог. Мал аж ахуй эрхлэхийн зэрэгцээ алт олборлоход хааяа юу ч олдоггүй ч мөнгөөр тасардаггүй амьдралд хэрэгтэй байдаг гэж хариулж байлаа.

6.2. Алт олборлох болсон гол шалтгаанууд

ХАМО нараас алт олборлох шалтгааныг асуухад судалгаанд оролцогч нарын 60,5% амьжиргаагаа залгуулахын тулд амьдралын эрхээр энэхүү ажлын хийж байна гэсэн бөгөөд алт олборлоход хүргэсэн хоёр дахь үндсэн шалтгаан нь хүүхдүүдийнхээ сургалтын төлбөрийг хийх, эсвэл хүүхэд залуучууд өөрсдийн сургалтын төлбөрөө хийхийн тулд найз нөхдөө дагуулан ирж алт ухдаг юм байна.



Сóдàа 6.2

Судалгаанд хамрагдагсдын 69,4% нь тухайн уурхайн газрууддаа нилээд тогтворт суурьшилтайгаар 1-3 жилийн хугацаанд ажиллаж байгаа ба харин 9,2% нь 3-аас доош сар ажиллаж байсан нь ихэвчлэн зуныхаа амралтаар ажиллаж байсан оюутан сургач нар байлаа. ХАМО иргэдийн тухайн алт олборлож буй газар ажилласан жилээр нь харуулбал 69,4 хувь нь 1-3 жил, 15.3 хувь нь 4-6 жил, 5.1 хувь нь 7-9 жил, 0.5 хувь нь 10-12 жил ажилласан байлаа. Харин хамгийн богино хугацаагаар буюу 3-аас доош сар алт олборлох ажил хийж буй ХАМО нар нь

ихэвчилэн оюутан залуучууд, орон нутгийн ХАМО нарын түр хугацаагаар ирсэн хамаатан саднууд байлаа.

ХАМО иргэдийн тухайн уурхайнуудад ажилласан хугацаа

Сонгогдсон үзүүлэлт	Эзлэх %
Хугацаа	
3-аас доош сар	9.2
7-12 сар	0.5
1-3 жил	69.4
4-6 жил	15.3
7-9 жил	5.1
10-12 жил	0.5
Нийт	100
Нийт ХАМО-н тоо	200

Однийд 5.1

Хувиараа алт олборлох явцад хамгийн том хүндрэл бэрхшээл, айдас юу вэ? гэсэн асуултад алт олборлогч нар маань ахуйн хэрэглээ, тав тухтай нөхцөл байдлынхаа төлөө ус цахилгаан, орон байрны асуудал гэхээсээ илүүтэйгээр дарагдах, нурах аюул осол, байгалийн баялаг өдрөөс өдөрт хорогдон алтны гарц багасаж байгаад санаа зовж байгаагаа илэрхийлж байлаа. Харин бусдын дарамт шахалт, бусдад гадуурхагдан дээрэлхэгдэхэд төдийлөн санаа зовохгүй байгаа нь ТоБУТ төслийн болон Байдрагийн хөгжил ТББ-ийн ХАМО иргэдийг нэгдсэн зохион байгуулалтад оруулахад чиглэсэн үйл ажиллагааны үр дүнтэй шууд холбоотой болох нь ажиглагдаж байлаа.



Соодлал 6.3

6.3. ХАМО иргэдийн зөвшөөрөлтэй газар үйл ажиллагаа явуулж байгаа байдал

Судалгааны явцад газрын асуудал нилээд хөндөгдөж байсан бөгөөд өөрсдийгээ Монгол Улсын засгийн газрын 72-р тогтоол, түр журамд заасны дагуу зөвшөөрөгдсөн газарт алт олборлолт явуулж байгаа хэмээн нийт оролцогчдын 91,5 хувь хариулсан байна. Гэсэн хэдий ч хууль эрх зүйн талаарх мэдээлэл, мэдлэг нийт хүмүүсийн дунд харилцан адилгүй байсны улмаас судалгаанд оролцогч нарын өгөн мэдээлэл хэр бодитойг тодруулахад хүндрэлтэй байлаа. Мөн үйл ажиллагаа явуулж байгаа нөхөрлөлүүд маань өгөгдсөн буюу зөвшөөрөгдсөн газрынхаа хэмжээг мэдэхгүй байх яг аль газар тэдний хувьд зөвшөөрөгдсөн зэргээ мэдэхгүй байх тохиолдолууд нилээд гарч байлаа.

Хувиараа алт олборлогчдын хувьд энэхүү ажлаа орхин өөр зүйл хийх болол байдаг эсэх талаар судлахад судалгаанд оролцогчдын 69,5% нь энэ ажлаа орхимоор байна гэж хариулж байлаа. Үүний шалтгааныг судалж үзэхэд оролцогчдын 1% хангалттай мөнгө олсон учир энэ ажлаа орхин өөр ажил, бизнес эрхлэх бодолтой байгаагаа илэрхийлсэн бол 11% нь биеийн эрүүл мэндийн байдал муудан цаашид ийм ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй болсон учир энэ ажлаа орхихоос өөр аргагүй болоод байна гэсэн байна. Мөн хариулагчдын 34% нь ажиллах нөхцөл байдал маш хүнд аюултай учраас боломж гарвал өөр зүйл хийхийг хүсдэг гэсэн ба 26,1% нь алтны гарц муудаж байгаа нь өдрийн орлогын хэмжээнд илэрхий нөлөөлж байгаад сэтгэл дундуур байгааг илэрхийлж өөр боломжийг хайж байна гэж байлаа. Харин үлдсэн хувь нь алт олборлон өөр газар гэр бүлээсээ хол байх, улирлын чанартай алт олборлох, цаг агаарын таагүй байдалд ажиллахад хүндрэлтэй байдаг зэрэг шалтгааны улмаас энэ төрлийн үйл ажиллагаагаа орхих юмсан гэж боддогоо хуваалцаж байлаа.

6.4. ХАМО иргэдийн ажил, амралтын горим

Монгол улсын Хөдөлмөрийн хуулийн 5 дугаар бүлэгт зааснаар 7 хоногийн ажлын цаг 40, ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 цаг хүртэл гэж заасан байдаг бол алт олборлогч нарын хувьд ажлын цагийн үргэлжлэх хугацаа нь алтны гарц, улирлын байдлаас ихээхэн хамааралтай байна. Тэд алттай ширеэ олдсон үед болон зуны улиралд өдөрт 8-аас дээш цагаар ажилладаг байна. Мөн судалгаа өгөгчдийн 23.6% нь ширүүн бороо орохоос бусад бүхий л тохиолдолд ажилладаг гэсэн бол 36.9% огт амардаггүй алт олохын төлөө болж л өгвөл ажилладаг гэж хариулж байлаа.

Сонгогдсон үзүүлэлт	Эзлэх %
Амралтын хугацаа	
1 өдөр	17,0
2 өдөр	13,5
3 өдөр	5,0

Зүйлсийн Огт амардаггүй	3< өдөр	3,0
Цаг агаар муу үед		37,5
		24,0

Однородно 6.2

Ажлын өдөрт алт олборлогсод дунджаар 10 цаг ажилладаг байна. Ажиглалт судалгааны явцад ажлын өдрийн цаг, ажлын завсарлага, долоо хоногийн амралтын өдөр зэрэг нь алт олдоц, улирлаас хамаардаг, тэдэнд баримтлах хөдөлмөр-амралтын тогтсон горим байдаггүй болох нь харагдаж байлаа.


Алт олборлох үйл ажиллагааг зогсоохоос өөр аргагүйд хүргэдэг байгаль цаг уурын нөхцөл байдлын талаар асуухад судалгаанд оролцогч нарын 78.3% ширүүн бороо, 18.7 хувь өвлийн хүйтэн, 17.7 цасан шуурга, 7.4 хувь шороон шуурга, 4.4 хувь нь халуун нартай байх гэж хариулснаас хараад алт олборлогч наарт хүндрэл учруулдаг байгаль цаг уурын хамгийн хүндрэлтэй нөхцөл байдал нь ширүүн бороотой үе байдаг байна. Ширүүн борооны улмаас нүх усаар дүүрэх, газрын хөрс норж супран хөрс нурах аюултай байдаг учраас борооноос бусад ихэнх цаг агаарын нөхцөл байдлыг тоолгүйгээр ихэнх ХАМО нар үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Сонгогдсон үзүүлэлт	Эзлэх %
Ихэвчлэн ажилладаг улирал	
Өвөл	4.4
Хавар	19.7
Зүн	69.0
Намар	14.8
4 улирал	24.6

Однородно 6.3

6.5. ХАМО нарын хөдөлмөрийн хуваарилалт, хүндрэл, ажлын үнэлгээ

Судалгаанд хамрагдсан алт олборлогсод нь нүх ухах, шороо зөөх, шигших, алттай шороог угаах гэсэн үндсэн ажлыг гүйцэтгэдэг байна. Алт олборлогсдын ажлын төрөл тэдний хүйсээс хамаарч байгаа эсэхийг судлахад эрэгтэй ажилчид, эмэгтэйчүүдийг бодвол чулуу бутлах газар ухах ажлыг хийдэг бол эмэгтэйчүүд шороо зөөх шигших (58,6 хувь), алттай шороог угаах (79,8 хувь), ус зөөх (28,6 хувь), шороо хүрздэж өгөх (29,1 хувь) зэргээр харилцан адилгүй ажлыг хийж гүйцэтгэдэг байна.



Соёл 6.4


Дээрх ажил хөдөлмөрөөс хамгийн хэцүү ажил нь хөлдсөн болон хөлдөөгүй газарт нүх ухах гэж судалгаанд оролцогчдын 64,5 хувь, өвлийн хүйтэнд алтаа угааж резиндэх гэж 22,7 хувь нь, цас хайлсны дараа болон бороо орсны дараа устай хүйтэн нөхцөлд газрын гүнд ажиллах гэж 13,3 хувь нь тус тус хариулсан.

ХАМО нараас хамгийн олон нь буюу 44% өдөрт 601-800 кг шороо угаадаг бөгөөд хамгийн багадаа 100 кг шороо өдөрт угааж дунджаар 0.4-0.75 грамм буюу 12000-24000 төгрөгний алт олборлож байна.

6.6. Ажлын байр, хөдөлмөрийн багаж хэрэгсэлийн хангальт

Судалгаанд хамрагдсан нийт ХАМО нарын 88.7 хувь нь хүрз, 35.5 хувь нь лоом, 41.4 хувь нь жоотуу, 52.2 хувь нь хувин, 41.9 хувь нь түмпэн, 17.2 хувь нь шуудай 11.3 хувь нь шигшүүр, 35.5 хувь нь сков, 1.5 хувь нь усны насос буюу памп, 4.4 хувь нь резин, 0.5 хувь нь шаланк, 7.9 хувь нь усан бүү, 3.9 хувь нь хуурай угаагч, 1.5 хувь нь пайжгар гэж хариулснаас үзэхэд хамгийн их хэрэглэдэг багаж хэрэгсэлд хүрз, лоом, жоотуу, түмпэн шуудай, сков зэргийг алт олборлох ажилд ашигладаг.

Судалгаанд хамрагдагсдаас ямар техник, багаж таны ажлыг хөнгөвчилдэг вэ? гэсэн асуултанд хамгийн их буюу 39.9 хувь нь хүрз, 20.7 усан буу, 16.3 хувь нь сков зэргийг хамгийн их ажил хөнгөвчилдэг багаж хэрэгсэл гэж нэрлэсэн бөгөөд экскаватор, бульдозер, усан насос, шлюзыг хэрэглэх сонирхол байгаа боловч үнэтэй, худалдаж авч дийлдэггүй учраас үнэ багатай, овор багатай хэрэгслүүдийг хэрэглэдэг нь ХАМО иргэдтэй уулзаж байх явцад ажиглагдлаа.



Çöðää 6.5



БҮЛЭГ 7

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ХЭРЭГЦЭЭ

7.1 Эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмж

Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд заасны дагуу Монгол улсны иргэн бүр эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусlamж авах эрхтэй гэж заасан байдаг. Судалгаанд хамрагдсан ХАМО иргэдийн 81.3 хувь нь сумын эмнэлгээр үйлчилгээдэг ба 5.9 % хувь нь аймгийн эмнэлгээр үйлчилгээдэг байна. Судалгаанд хамрагдсан алт олборлогсод өвдсөн үедээ 66 % нь сумын их эмчээр, 16.3 % нь тус уурхайн бага эмчээс эмнэлгийн анхан шатны тусlamж авдаг байна.



Соёлд 7.1

Алт олборлогсдын авч байгаа эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг төрлөөр нь авч үзвэл 59.1 хувь нь анхан шатны, 8.4 хувь нь нарийн мэргэжлийн тусlamж, 7.9 хувь нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, оношлуулах, үйлчилгээг авдаг байна. Эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхэд сумын төвийн эмнэлгийн зүгээс урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо явуулдаг боловч ХАМО иргэдийн дунд өвчлөлийн нарийн судалгаа байдаггүй төдийгүй зайлшгүй шаардлагатай эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх үед л сумын төвийн эмнэлэгээр үйлчилгээдэг бусад ихэнх тохиолдолд уурхайн бага эмчээс л анхан шатны тусlamж авдаг юм байна.

Мөн сумын төвийн эмнэлэгт төсөв мөнгө хүрэлцээгүй байдгаас нэг унаагаар нийт сумын төвийн 3049 иргэдэд үйлчилгээд хугацаа алдах, хүндрэл гардаг нь ХАМО иргэд, сумын төвийн эмч болон орон нутгийн удирдлагуудтай хийсэн ярилцлагаас харагдаж байлаа. Судалгаанд оролцогчдын 17.7 хувь нь эмнэлгийн анхан шатны тусlamж авахад хугацаа алддаг, 4% нь эмнэлгийн тусlamжийг 2-12 цагийн дотор авах боломжтой гэж хариулсан байна. Иймд ойр байгаагаар нь уурхай дээр ажиллаж байгаа бага эмчээс тусlamж авах явдал түгээмэл байдаг ба нөгөө талаас бага эмчид ХАМО нарт үйлчилгээ үзүүлэхэд, эмчлэн сувилахад тохиромжтой ажлын байраар хангагдаагүй байдаг нь бүлгийн ярилцлага болон ганцаарчилсан ярилцлагаас ажиглагдлаа. Иймд цаашид ХАМО иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй, хурдан шуурхай, чанартай болгохын тулд сум орон нутгаас төсөв хөрөнгийг нь шийдвэрлэж нарийн мэргэжлийн эмчийн орон тоо

гаргаж, эмч ажиллах ажлын байрны нөхцлийг бүрдүүлж ХАМО иргэдэд эрүүл мэндийн үзлэг оношлогоог цаг алдалгүй үзүүлж байх нь зүйтэй санагдлаа.

7.2 ХАМО иргэдийн эрүүл мэндийн байдал

ХАМО иргэдийн дунд зонхилон тохиолддог өвчний талаар асуухад газар дор, усан дотор чийгтэй газар удаан зогсох, өвлийн хүйтэнд хөлдүү газар шороо ухах хүнд ачаа өргөдөг, хүйтэн усаар байнга шороо угаадаг мөн булгийн ус нь үерийн устай холилдож ундны ус нь баталгаагүй байдаг зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалж ХАМО иргэдийн дунд дараах өвчлөлүүд их тохиолддог нь харагдаж байлаа. Тухайлбал 37.4% буюу 76 хүн бөөр, шээсний замын өвчний зовиур, 26.7% буюу 60 хүн үе мөчний өвчний зовиур, 5% буюу 11 хүн нь амьсгалын замын өвчний зовиур, 3% нь буюу 6 хүн хоол боловсруулах замын өвчний зовиур илэрсэн харин 27.9 хувь буюу 47 хүн алт олборлон ажиллаж эхэлснээс хойш ямар нэгэн өвчний зовиур илрээгүй гэж хариулсан байна.



Соодлал 7.2

Ихэнх ХАМО иргэд нь ажил амралтын горим нь алдагдаж өдрийн 8-12 цагийг алт олборлоход зарцуулдаг ба эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагатай ч гэсэн амьжиргаагаа залгуулахын тулд өвчин намдаах төдий эм уун архагшуулах явдал олонтоо тохиолддог нь судалгааны явцаас мөн ажиглагдлаа.

Одийн эдийн ёдөй ажлыг өдөрнийдээ 100% түүхийн 37% нь бөөр, шээсний замын өвчний зовиур, 27% нь үе мөчний өвчний зовиур, 5% нь амьсгалын замын өвчний зовиур, 2% нь зүрх судасны өвчний зовиур, 1% нь хоол боловсруулах өвчний зовиур, 28% нь зовиур илрээгүй. Ганцаарчилсан ярилцлага иргэн Д

7.3 ХАМО иргэдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тохиолддог осол аваарууд , тэдгээрийн шалтгаан

Алт олборлох ажил эрхэлснээс хойш ажлын байран дээрээ тэдний 10.3% нь ямар нэгэн осолд өртөж байсан ба 6.9% нь 1-2 удаа, 2.5 хувь нь 3-4 удаа гэмтсэн давтамжтай байв. Харин ихэвчилэн ямар төрлийн осол аваар гардаг вэ гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 53.7% буюу 109 нь угаартах, 11.3 % буюу 23 хүн нь шороонд дарагдах, 3% буюу 6 хүн түлэгдэх гэж хариулсан бөгөөд нэг хүн угаартаж амь наасаа алдсан.

Хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой гэмтлийн зонхилон тохиолдож буй шалтгаанд шороонд дарагдсан 2.5%, 0.5% нь түлэгдсэн, 5.4 % нь угаартсан 91.6 хувь нь огт гэмтэл авч байгаагүй гэж хариулсан байна. Үүнээс харахад осол гэмтэл харьцангуй бага гардаг энэ нь хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм журмыг нөхөрлөлийн ахлагч, “Байдрагын хөгжил”ТББ, Тогтвортой бичил уурхай төслийн хүрээнд энэ талаархи ойлголт мэдлэгийг сайн өгдөгтэй холбоотой байгаа нь бүлгийн ярилцлага болон ганцаарчилсан ярилцлагаас харагдаж байсан.



Соодлал 7.3

Судалгаанаас харахад осол аваарын гол шалтгааныг 46.8% буюу 95 хүн нь хайхрамжгүй байдлаас, 20.2% буюу 41 хүн аюулгүй ажиллагааны журам мэдэхгүйгээс, 13.3% буюу 27 хүн нь газрын хөрс зөөлөн, нурамхай, 10.3% буюу 21 нь аюулгүй ажиллагааны журам мэддэг ч амьдралд хэрэгжүүлдэггүйгээс 7.4% нь буюу 15 нь хөдөлмөр хамгааллын багаж хэрэгсэл дутмагаас осолд аваарт өртдөг гэж үзсэн.

Нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсноор нэг нь бусдынхаа аюулгүй байдлын төлөө анхаарч өглөө ажилдаа гарахад аюулгүй ажиллагааны дүрэм журам баримталж ажиллахыг сануулж гарын үсэг зуруулаад шруул уруу оруулдаг болсон нь биднийг осол аваарт өртхөөс хамгаалж л байгаа гэсэн үг юм. Цаашид бүх хүмүүс өөрсдөө хэрэгжүүлээд хэвшивэл бидэнд л хэрэгтэй шүү дээ.

Ганцаарчилсан ярилцлага Иргэн С

7.4 ХАМО иргэдийн ЭМД-ын төлөлтийн байдал

Судалгаанд хамрагдагсдын 84.2 хувь нь буюу 171 хүн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан, 14.3 хувь буюу 29 хүн эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй үзүүлэлттэй байна. Мөн түүнчилэн 64 хувь буюу 130 нь эрүүл мэндийн даатгалын хураамжаа төлсөн байлаа. Нийт даатгалын хураамжаа төлөөгүй байгаа иргэдийн 15.8 хувь нь мөнгө санхүүгийн боломжгүйгээс төлөөгүй гэж хариулсан байна. Эдгээр үзүүлэлтээс харахад эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт нийгмийн даатгалын шимтгэлээс илүү төлж байгаа нь шимтгэлийн үнэ хямд мөн сумын төвийн эмнэлгээс эмч нар ирж сургалт сурталчилгаа хийж даатгалын байцаагч уурхай дээр ирж ажиллан шимтгэлээ хурааж авдаг учраас ХАМО наарт ямар нэгэн хүндрэл гардаггүйтэй холбоотой байлаа. Мөн бүлгийн ярилцлагын үеэр ТоБҮТөсөл болон Байдрагийн хөгжил ТББ-ын зүгээс ХАМО нарын хөдөлмөрийн байрны аюулгүй ажиллагаа, хариуцлагатай бичил уурхайчин байх тал дээр сургалт сурчилгааны ажил ихээхэн хийж байгаатай уялдуулан ХАМО нарын эрүүл мэнддээ анхаарах, ЭМД-ын ач холбогдолыг ойлгох байдалд эрс өөрчлөлт орсон тухай холбогдох хүмүүс ярьж байлаа.



Соёлд 7.4

7.5 ХАМО иргэдийн НД-ын төлөлтийн байдал

Алтнаас олсон орлогоосоо нийгмийн даатгал төлдөг үү гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 37.4 хувь нь төлдөг, 61.1 хувь нь төлдөггүй гэж хариулсан байлаа. Тэдний 21.2 хувь нь төлбөрийн чадваргүй, 16.3 хувь төлөх аргаа мэдэхгүй, 5.9 хувь нь нийгмийн даатгалд даатгуулахыг хүсдэггүй, 3 хувь нь завгүй гэх шалтгаанаар төлдөггүй гэж хариулжээ.


Нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдлын талаар асуухад 62.1 хувь нь тэтгэвэр авахад, 21.7 хувь нь тэтгэмж авахад, 14.8 хувь нь осол гэмтлийн даатгал авахад 16.7 хувь нь хүн нийгмийн даатгалын ач холбогдлыг мэдэхгүй гэж хариулсан байна.

Нийгмийн халамжийн ямар үйлчилгээ шаардлагатай байна вэ? гэсэн асуултанд 58.1 хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээ шаардлагагүй, 9 хувь нь өндөр

насны тэтгэмж авахад, 6.4 хувь хүүхдийн мөнгөн тэтгэмж, 6.9 хувь нь нэн ядуу иргэдийн тэтгэмж, 2.5 хувь нь хүүхэд асарсаны тэтгэмж гэж хариулсан байна.

7.6 ХАМО иргэдийн ХАОАТ-ын төлөлтийн байдал

Алтнаас олсон орлогоос орлогын албан татвар төлдөг эсэх талаар судлахад 96 хувь нь төлдөггүй болох нь харагдсан бөгөөд тэднээс ямар шалтгааны улмаас ХАОАТ-аа төлдөггүй талаар лавлахад 55 хувь нь энэ талаар мэдээлэл байхгүй, 37 хувь нь төлбөрийн чадваргүй, 6 хувь нь төлөх аргаа мэдэхгүй, 2 хувь нь завгүй, 4 хувь нь төлдөг гэж хариулсан байна. Судалгааны явцад ХАМО иргэд хүн амын орлогын татварыг газрын татвараас ялгаж салгаж ойлгохгүй байгаа нь анзаарагдсан юм. Мөн сумын байгаль орчны байцаагч ХАМО иргэдээс сар бүр хурааж байгаа 9000 төгрөгийг орлогын албан татвартай андуурдаг ба энэ мөнгө нь хаашаа юунд зарцуулагддаг талаар мэдээлэл дутмаг байгаа нь ажиглагдсан. Судлаач ХАМО нараас судалгаа авч байх үедээ ялгаж салган тайлбарлаж өгөхөд орлогын албан татвар төлдөг хүн 4 хувь байсан ба 96 хувь нь хүн амын орлогын албан татвараа төлдөггүй байдал харагдаж байна.



Соодлал 7.5



БҮЛЭГ 8

**ХАМО ИРГЭДИЙН ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА**

8.1. ХАМО иргэдийн дундахь нөхөрлөлийн зохион байгуулалт

Жаргалант суманд хувиараа алт олборлож буй судалгаанд хамрагдсан иргэдийн 92 хувь нь нөхөрлөлийн талаар сонссон бөгөөд 78.3 хувь буюу 159 ХАМО иргэн нөхөрлөлийн гишүүн болсон байна. Одоогийн байдлаар БХТББ нь нийт 35 нөхөрлөл, 500 гаруй гишүүд байгаагаас энэхүү судалгаанд бүх нөхөрлөлөөс төлөөлөн тодорхой тооны гишүүд судалгаанд хамрагдсан байна. БХТББ нь Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, Тэргүүн гэсэн бүтэцтэй бөгөөд нөхөрлөлийн ахлагч нар нь Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд багтдаг.

Нөхөрлөлд орсон хугацаагаар нь авч үзвэл нөхөрлөлд ороод 3 сар болж байгаа ХАМО 70 4-12 сар болж байгаа 64 12сараас дээш болж байгаа 26 иргэд байлаа. Нөхөрлөлд ороогүй байгаа ХАМО нарын хувьд 5.9 хувь буюу 12 нь нөхөрлөлийн талаар сайн мэдэхгүй, 0.5 хувь буюу 1 хувь нь санаа нийлсэн хүн байхгүй, 0.5 хувь буюу 1 хүн нөхөрлөлд ороод хэрэггүй ашиггүй гэж хариулж байлаа.

Óðüä iü iðü íóðæééí èðäýäýýñ ãàäíà ãàäíû èðäýä àëò iëáîðëiðñð èðñíýýñ àððèäàëò, çàìààðàðãçéäýë, ðýðççë çïäññ, ðç÷èððèéëýë, iëññ i°äåºº çºâ çééëä çàððóóéëäàðãçé áàðñàí áíë i°ð°ðé°ëä iðñññð çïðeññ áàððóóéëàðàíä iðæ lÓ-úí ÇÃ-úí 72-ð ðiððñññü íàððóóéëä iðü íóðæééí ðàðüýäëàðãçé èðäýä áàðæíàð ñàððàðãðí ãàð÷ aððèäàëò áàððàñ÷, áìüæèððàðàðàðà äýþöëççéýðééí ð°ëºº ççðäýæ àëðíàðñ iëññ iñððíññðñ óíàà ìàë àðñàí. Iñíñiè óëñàä ièíü aðò iëáîðëíæ áàððàð ÕÀÍÍ iàðñàä çàñàä çàððèððàð iü ñóððàí çïðeññ áàððóóéëàðàíä iððóóëæ áè÷èë óóððàðéä ðºðæççéýñé.

Áàðóóí ñàëàà èðãýí Á



Çóðàã8.1

ХАМО иргэдийн Монгол улсын засгийн газрын 72-р тогтоол, Түр журам батлагдаж амьдралд хэрэгжиж эхэлснээр олон ХАМО иргэд алтнаас амьжираагаа залгуулж өрх, гэр, сум орон орон нутаг болон улсынхаа хөгжилд хувь нэмэр оруулж яваадаа сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж байлаа.

Нөхөрлөлийн гишүүдийн хувьд алтнаас олсон ашгаа 64 хувь нь тэгш хуваадаг, 10.3 хувь нь хийснээрээ авдаг, 3 хувь нь нөхөрлөлийн ахлагч хуваадаг гэж хариулсан ба 76.8 хувь буюу 156 хүн нөхөрлөлийн гишүүдийн ашгаа хувааж байгаа байдалд сэтгэл хангалуун байдгаа, 1 хувь сэтгэл дундуур явдаг гэж хариулсан байна. Үүнээс харахад нөхөрлөл болон ажиллаж байгаа ХАМО нар алтнаас олж буй ашгаа хувааж авах тал дээр сэтгэл хангалуун явдаг нь харагдаж байна. Өдөрт олсон алтаа нөхөрлөлийн гишүүд хамт байлцаж борлуулан ашгаа тэгш хуваадаг нь ярилцлагаас харагдсан.



Соёл 8.2

Нөхөрлөлийн гишүүдийн 77.3 хувь буюу 157 хүн нь алт олборлох газрын албан ёсны зөвшөөрөлтэй гэж хариулсан ба 69.5 хувь буюу 141 хүн зөвшөөрөлтэй газрынхаа хэмжээг мэдэхгүй байсан. Бидний судалгаа хийсэн газар болох Баруун, Зүүн салаа, Анагт алт олборлуулахаар зөвшөөрсөн талбайг тодорхой сайн мэдэхгүй байгаа нь ажиглагдаж байсан ба энэ нь нөхөрлөл бүрт газрыг тогтоож өгөөгүй байдагтай холбоотой юм байна гэсэн дүгнэлтэнд хүрсэн. Мөн аймгийн болон сумын байгаль орчин болон бичил уурхай хариуцсан ажилтнууд болон ХАМО иргэдийн ярианаас тодорхой байсан.

8.2 Байдрагийн Хөгжил ТББ-ийн үйл ажиллагааны талаарх ХАМО иргэдийн санал, үнэлээмж

Нийт судалгаанд хамрагдсан ХАМО иргэдийн 69.5 хувь буюу 139 хүн “Байдрагийн хөгжил” ТББ-ын талаар мэддэг гэж хариулсан бөгөөд 30.5 хувь буюу 60 хүн энэ байгууллагын талаар мэдэхгүй гэж хариулж байлаа.

Сонгогдсон үзүүлэлт	Хувь
Сургалт явуулдаг	24.1%
ХАМО нарын эрх ашгийг хамгаалдаг	35 %
Нөхөрлөл бий болоход тусалдаг	13.3%
ХАМО иргэдийн оролцоог дэмждэг	3.9%
Ажлын байрны аюулгүй байдалд анхаардаг	14.8%
Тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхийн төлөө ажилладаг	11.8%

ХАМО нарыг зохион байгуулалтайгаар алт олборлоход гол үүрэг гүйцэтгэдэг	11.8%
Мэдээллээр хангадаг	10.3%
Мэдэхгүй	18.7%
Сонссон боловч үйл ажиллагааг нь сайн мэдэхгүй	10.3%

Одийн 8.1

Судалгаанд оролцсон ХАМО иргэдээс ямар байгууллага таны эрх ашгийг хамгаалж ажилладаг вэ? гэсэн асуултанд дийлэнх буюу 25 хувь нь Байдрагийн Хөгжил ТББ-ыг ХАМО нарын эрх ашгийг хамгаалж ажилладаг, сургалт сурталчилгаа хийдэг, алт олборлоход аюулгүй байдлыг хангаж ажиллуулдаг гэсэн хариултуудыг хэлж байсан. Эдгээрээс харахад “Байдрагийн хөгжил”ТББ хэдийгээр байгуулагдаад нэг жил болж байгаа ч ХАМО иргэдийн дунд үйл ажиллагаа нь хүлээн зөвшөөрөгдсөн гэдэг нь харагдаж байлаа. Мөн түүнчилэн аймаг сумын удирдлагуутдай уулзаж байх үед ХАМО иргэдтэй ойр дотно сайн хамтран ажилладаг гэдгийг дурьдаж байсан юм. Байгууллагын өөрийнх нь хувьд байгуулагдаад удаагүй байгаа учраас сурх боловсрох хэрэгцээ шаардлага байгааг тухайн байгууллагын удирдлагууд ярилцлагын явцад илэрхийлж байсан тухайлбал: байгууллагын зөв менежмент, санхүүжилт хэрхэн босгох, хүн хүчээ нэмэгдүүлэх зэрэг талууд дээр илүү их хөгжих хэрэгцээ шаардлага байна гэж байлаа.

8.3. ХАМО иргэдийн хамгийн их хэрэгцээтэй байгаа зүйл




Соёлд 8.3

Судалгаанд хамрагдагсдын 47.3 хувь нь амьдарч байгаа газар нь хамгийн хэрэгцээтэй байгаа ямар үйлчилгээ байна вэ гэсэн асуултанд халуун ус, 23.6 хувь нь эмнэлэг, 18.7 хувь нь харилцаа холбоо, 14.7 хувь нь цэцэрлэг гэж хариулсан бол үзвэр үйлчилгээ, сургууль банкны үйлчилгээ, чөлөөт цагаа өнгөрөөх газар зэргийг бага дурьдсан байна. Үүнээс харахад ХАМО иргэд шороо тоос, чийгтэй

газар ажилладагтай холбоотойгоор халуун усны үйлчилгээг хамгийн их дурьдсан байна.

Нийт судалгаанд хамрагдсан ХАМО иргэдийн дунд Таны эрх ашгийг хамгаалж ажилладаг ямар байгууллага байдаг вэ гэсэн асуултанд олонх нь 43.8 хувь нь Тогтвортой бичил уурхай төсөл, 36.5 хувь нь Байдрагын хөгжил ТББ гэж хариулсан ба үлдсэн хэсэг нь нөхөрлөл, сумын засаг захиргааг эдгээр байгууллагуудын дараа тэдний эрх ашгийг хамгаалж ажилладаг байгууллага гэж нэрлэсэн байна. Үүнээс харахад Тогтвортой бичил уурхай төсөл болон Байдрагийн хөгжил ТББ ХАМО иргэдтэй хамгийн ойр дотно ажилладаг нь харагдаж байна.



Соодлал 8.4

БҮЛЭГ 9

ДҮГНЭЛТ

- Баянхонгор аймгийн Жаргалант сум нийт 876 өрх, 3049 хүн амтай буюу нийт хөдөлмөрийн насны хүн амын 60-80 хувь нь урт богино хугацаагаар гэр бүлээрээ болон хамаатан саднаараа алт олборлох үйл ажиллагаанд оролцдог байна.
- Судалгаанд оролцсон нийт ХАМО иргэд жилдээ 13,75 орчим кг алт олборлож, 440,0 гаруй сая төгрөгийн орлого олдог байна. Тэдний жилийн ашгийн түвшин 59% байна. Олборлосон алтаа Монголбанкны ханшаас 36 хувийн доогуур ханшаар албан бус захаар газар дээрээ борлуулдаг. Иймээс ХАОАТ төлөлтийн хувь маш бага гарч байна.
- Ажлын нөхцөл байдал хүнд, эрүүл мэндэд шууд нөлөөлдөг учраас алт олборлох ажлаасаа илүү мал худалдаж авах, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй ХАМО иргэд их байна.
- Судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх нь алтны нөөц дуусч байгаад санаа зовж цаашид амьжиргаа залгуулах эх үүсвэргүй болж олноороо ажилгүй болох тал дээр эмзэглэж байлаа.
- Уурхай нь зах зээлээс хол, алт нь хөрвөх чадвар сайтай бэлэн мөнгөнд шууд хөрвөдөг учраас тухайн газарт зарагдаж буй бараа таваарын үнэ харьцангуй өндөр үнэтэй байгаа нь ажиглагдаж байлаа. Ихэнх ХАМО нар олсон орлогынхоо ихэнхийг хоол хүнсэндээ зарцуулан амьжиргаагаа залгуулж, хуримтлал үүсгэж чаддаггүй байна.
- ХАМО иргэд нь бусад газруудыг бодвол нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсон байгаа нь ХАМО иргэдийн ажлыг хөнгөвчилж, хамт олноороо асуудлаа шийдвэрлэх, ашиг орлого нь нэмэгдэх, аюулгүй ажиллагааны дүрэм журмын талаар мэдлэгтэй болж, хамгийн чухал зүйл болсон газрын зөвшөөрөл авч аюулгүй орчинд ажиллах нөхцөл бүрдсэн байна.
- ХАМО иргэдийн дунд нийгмийн даатгал болон хүн амын орлогын албан татвар төлөхгүй байгаа нь тэдний дунд энэ талаар ойлголт мэдлэг бага, төлөх аргаа мэдэхгүй, энэ талаарх мэдээлэл суртчилгаа дутмаг байгаа нь ажиглагдлаа. Улмаар эдгээр хүмүүсийн тоо жилээс жилд нэмэгдвэл хэдэн жилийн дараа тэтгэвэр тэтгэмж авах насандаа эрхээ эдэлж чадахгүй иргэдийн тоо нэмэгдэх хандлагатай байна.
- Жаргалант сумын Баруун, Зүүн салаа, Анагт үйл ажиллагаа эрхэлж байгаа ХАМО иргэдийн дунд нийгмийн эмх замбараагүй байдал, далд, ажилгүйдэл,

хүчирхийлэл, танхайрал болон бусад төрлийн гэмт хэргүүд байхгүй болж зөвхөн амьдралынхаа төлөө зүтгэж алтнаас олж байгаа орлогоо өрхийн амьжиргааны эх үүсвэр болж байлаа.

- Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл хэрэглэх сонирхолтой иргэд их байсан ч энэ нь олддоггүй хаанаас авахаа мэдэхгүй зэрэг хүндрэлүүд гардаг байна.

БҮЛЭГ 10

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны үеэр цуглуулсан мэдээлэл, тэдгээрт хийсэн үнэлэлт дүгнэлт дээр үндсэн ТоБУТөслөөс явуулж байгаа үйл ажиллагаанд үр дүн тус бүрээр дараах зөвлөмжийг гаргаж байна.

1. Бичил уурхайн салбарт ил тод, шударга бодлого эрх зүй, зохицуулалтын орчин бүрдүүлж, хэрэгжилтийг эхлүүлсэн байх

- Нөхөрлөлийн зохион байгуулалтанд нэгдэж, ХАМО иргэд газрын зөвшөөрөлтэй газар ажиллаж байгаа учраас цаашид алтны нөөц жилээс жилд багасч байгааг харгалзан өөр алтны нөөцтэй газар олгон тэднийг хариуцлагатай бичил уурхайчин болон ажиллах боломж бүрдүүлэх.
- Нийгмийн даатгалын шимтгэл болон хүн амын орлогын албан татвар төлөлтийн хувийг эрүүл мэндийн даатгал төлөлтийн хувьтай харьцуулахад бага үзүүлэлттэй байгаа учраас үүний ач холбогдлыг ухуулан таниулах, ойлголт мэдлэгийг нь нэмэгдүүлэх ажлыг системтэй зохион байгуулах
- Сум, орон нутгаас авч буй татвар хураамжийн талаар ХАМО нарт ойлголт мэдлэг олгох, үүний ач холбогдлыг ойлгуулах таниулах ажлыг зохион байгуулах.

2. Бичил уурхайн бүх түвшинд бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг сайжруулсан байх

- ХАМО нарын эрх ашгийг хамгаалан ажиллаж байгаа ТББ-ын үйл ажиллагааг дэмжин цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулах боломж бололцоогоор хангаж ажиллах
- Нөгөөтэйгүүр нөхөрлөлийн гишүүд буюу ТББ-ын гишүүдийг идэвхжүүлэх, эрх ашгийг хамгаалан ажилладаг байгуулагатайгаа хамтран өөрсдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд идэвхтэй оролцдог болох хандлагыг суулгах ажлуудыг зохион байгуулах
- Хувиараа ашигт малтмал олборлогсдын хувьд бие хүний хувьд хөгжих боломж хязгаарлагдмал, ажил, амьдралын нөхцөл байдал хэцүү бэрхшээлтэй байдгаас сэтгэлээр унах, аиж эмээх, сэтгэл санаа тавгүйтэх зэрэг үзэгдэл байдаг тул тэдэнд сэтгэлзүйн хувьд зөвлөгөө өгөх мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэлзүйч ажиллуулах.

3. Бичил уурхай эрхлэгчдийг үр ашигтай хариуцлагатай бичил уурхай болон бусад бизнесийн үйл ажиллагааг эрхлэх чадвартай болгоход нь дэмжлэг үзүүлэх

- ХАМО иргэдийн хөдөлмөрийг хөнгөвчлөх үүднээс тэднийг энгийн, хямд төсөр, ашиглаж болохуйц техник, тоног төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын

хувцастай болоход туслах, үүнийг бичил санхүүгийн харилцаа буюу жижиг зээл, түрээсээр дамжуулан хэрэгжүүлэх

- ХАМО иргэд өөр ажил хийх хүсэл эрмэлзэлтэй байгааг анхааран тэдний мэргэжил, ур чадварт тохирох ажлын байр бий болгох, алт олборлооос өөр ажлын ур чадвар, арга ухаан эзэмшүүлэхийн тулд сургалтанд хамруулах, зөвлөгөө өгөх, тэднийг гарын авлага, зөвлөмж зэрэг баримт материалыар хангах үйл ажиллагааг явуулах
- ХАМО иргэдийн эрхэлж буй үйл ажиллагааны аюултай, эрсдэлтэй, эрүүл мэндэд хор хөнөөлтэй байдлыг харгалzan эрүүл мэндийн байнгын үзлэгт жилд хоёроос доошгүй удаа хамруулах ажлыг зохион байгуулах.

4. Бичил уурхай эрхлэгчид ба бусад нөөц ашиглагчдыг байгаль экологи, нийгмийн асуудалд хариуцлагатай хандаж, гарч буй зөрчлийг шийдэж чаддаг чадвартай болгох

- ХАМО иргэдийг амьдарч, ажиллаж буй орчинд эрүүл мэндийн эрсдэлийг бий болгох, байгаль орчинд хор хөнөөл учруулахаас урьдчилан сэргийлэх үүднээс нөхөн сэргээлтийг тогтмол хийлгэх, байгаль орчинд халгүй технологийг хэрэглэх зааварчилгааг байнга өгөх

ХАВСРАЛТУУД

ХАВСРАЛТ 1.**СУДАЛГААНЫ БАГИЙН ГИШҮҮДИЙН НЭРС**

Багын ахлагч	
В.Бэрцэцэг	Хөгжлийн эзэд ТББ, судалгааны багийн ахлагч
Тайлан бичсэн	
В.Бэрцэцэг	Хөгжлийн эзэд ТББ, судалгааны багийн ахлагч
Д.Отгончимэг	Хөгжлийн эзэд ТББ-ийн судлаач
Тоон мэдээллийг цуглуулсан багийн гишүүд	
В.Бэрцэцэг	Хөгжлийн эзэд ТББ, судалгааны багийн ахлагч
Э.Батцэнгэл	Хөгжлийн эзэд ТББ-ийн судлаач
Х.Отгонсүрэн	Хөгжлийн эзэд ТББ-ийн судлаач
Д.Отгончимэг	Хөгжлийн эзэд ТББ-ийн судлаач
Д.Туяадэлгэр	Хөгжлийн эзэд ТББ-ийн судлаач
Чанарын мэдээлэл цуглуулсан багийн гишүүд	
Ч.Батзул	Хөгжлийн эзэд ТББ-ийн судлаач
В.Алтанцэцэг	Хөгжлийн эзэд ТББ-ийн судлаач
Н.Отгончимэг	Хөгжлийн эзэд ТББ-ийн судлаач
В.Бэрцэцэг	Хөгжлийн эзэд ТББ, судалгааны багийн ахлагч
Х.Отгонсүрэн	Хөгжлийн эзэд ТББ-ийн судлаач
Нийгэм эдийн засгийн мэдээлэл цуглуулсан багийн гишүүд	
Н.Мөнх Очир	Хөгжлийн эзэд ТББ-ийн судлаач
Ч.Батзул	Хөгжлийн эзэд ТББ-ийн судлаач
Мэдээлэл боловсруулалт	
В.Батчимэг	Хөгжлийн эзэд ТББ-ийн судлаач
В.Алтанцэцэг	Хөгжлийн эзэд ТББ-ийн судлаач
Мэдээлэл шивэгчид	
М.Зоригт	Хөгжлийн эзэд ТББ-ийн судлаач
Д.Туяадэлгэр	Хөгжлийн эзэд ТББ-ийн судлаач
Э.Батцэнгэл	Хөгжлийн эзэд ТББ-ийн судлаач

ХАВСРАЛТ 2**Баянхонгор аймгийн Жаргалант сумын өрхийн амьжиргааны түвшинг
оролцооны аргаар хийсэн үнэлгээ**

2009-7-27

Өрхийн амьжиргаан ы чадавхийн хэмжүүрүүд	Баян	Дундаж	Дундажаас доош
Ам бүлийн тоо	2-4	3-8	2-12
Боловсрол	Бүрэн бус дунд, Дээд, бүрэн дунд	Бүрэн бус дунд, дээд	Бага, мэргэжилгүй
Хөдөлмөр эрхлэлт	Хувиараа бизнес эрхэлдэг	Малчид, төрийн байгууллагын ажилчид, хувиараа бизнес эрхэлдэг хүмүүс	Ажилгүй, мал нь цөөн
Орон сууцны нөхцөл	2 давхар хаузтай, гэртэй	Байшин, хашаатай	4-5 ханатай гэр
Хөрөнгө	Дэлгүүртэй, колонктой, газартай, компьютертэй, нарны гэрэлтэй, телевизор, үнэтэй гар утас, CD тоглуулагчтай	Машин, ТҮЦ, жижиг дэлгүүр, мотор, телевизор, газартай, гар утас, CD тоглуулагчтай	Хятад цахилгаан хэрэгсэлтэй, хямд гар утастай,
Малын тоо	1000 аас дээш	50-100	20 оос доош
Тээврийн хэрэгсэл	4 төрлийн машин/ланд, УАЗ 469, пургон, суудлын машин/	1 төрлийн машин	Хятад мотоцикл
Тусlamж дэмжлэг	Хүүхдийн мөнгө	Хүүхдийн мөнгөн тусlamж, тэтгэвэр, групп, ах дүү хамаатны тусlamж	Халамжийн мөнгө, тэтгэвэр тэтгэмж
Хадгаламж	5 сая	100 мянга-200 мянга	-
Нийт эзлэх хувь	20%	50%	30%

ХАВСРАЛТ 3**Ганцаарчилсан ярилцлаганд оролцсон иргэд**

№	Нэрс	Албан тушаал
1	н.Оюунчимэг	Баянхонгор аймгийн Тамгын газрын дэргэдэх БО газрын харилцааны бодлого хариуцсан мэргэжилтэн
2	н.Идэрмөнх	Баянхонгор аймгийн Байгаль орчны улсын байцаагч
3	н.Нанзаа	Сумын засаг дарга
4	н.Бямбаа	Жаргалант сумын нийгмийн бодлогын дарга
5	н.Далхаа	БОХ улсын байцаагч
6	н.Дэнсмаа	Жаргалант сумын байгаль орчны байцаагч
7	н.Янжмаа	Жаргалант сумын ХААН банкны эрхлэгч
8	н.Саранзаяа	Жаргалант сумын Монгол шуудан банкны эрхлэгч
9	н.Болорчулуун	Жаргалант сумын эмэгтэйчүүдийн эмч, их баригч
10	н.Дэнсмаа	Жаргалант сум бага эмч
11	Николай Николаевич	ЖАМП алтны уурхайн дарга
12	н.Батзориг	Байдрагийн хөгжил ТТБ-ын тэргүүн
13	н.Оюун-Эрдэнэ	Жаргалант сумын дэлгүүрийн эзэн
14	н.Баярсайхан	ХАМО иргэн

ХАВСРАЛТ 4

Бүлгийн ярилцлаганд оролцсон оюутнууд

№	Нэрс	Сургуулийн нэр
1	н.Баянжаргал	СУИС
2	н.Ууганбаяр	МУИС
3	н.Түмэнбаяр	Барилгын коллеж
4	н.Алтансэлэнгэ	Төмөр замын дээд сургууль
5	н.Ганбаяр	МУБИС
6	н.Баяржаргал	СУИС
7	н.Алтанбагана	Түшээ дээд сургууль
8	н.Батжаргал	МУБИС
9	н.Түмэнжаргал	ГЭДС
10	н.Түмэнбаяр	Барилгын Технологийн коллеж

ХАВСРАЛТ 5**ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧ ИРГЭДЭЭС
АВАХ СУДАЛГААНЫ АСУУМЖ**

1. Ярилцлага авсан огноо	
2. Судалгаанд хариулагчийн дугаар	№
3. Судлаачийн дугаар	№
4. Асуулга авсан багийн нэр	1. Намтолгой 2. Өлзийт өндөр 3. Хөндлөн булаг 4. Эмээл толгой
5. Уурхайн газрын нэр	1. Жаргалант 2. Анаг 3. Бусад
6. Ямар уурхайн орд болох	1. Үндсэн орд 2. Шороон орд

1-р хэсэг: Ерөнхий мэдээлэл

101.	Судалгаанд оролцогчийн хүйс	Эр	1
		Эм	2
102.	Та хэдэн настай вэ?	(16-18)	1
		(19-25)	2
		(26-35)	3
		(36-45)	4
		(46-55)	5
		(56-65)	6
		(65<)	7
103.	Та ам бүл хэдүүлээ амьдардаг вэ?		
104.	Та хүүхэдтэй юу?		
105.	Та бичиг үсэг мэддэг үү?	Мэддэг	1
		Мэддэггүй	2
106.	Та ямар боловсролтой вэ?	Боловсролгүй - 1	1
		Бага боловсролтой	2
		Бүрэн бус дунд	3
		Бүрэн дунд	4
		Тусгай дунд	5
		Дээд	6
107.	Таны гэрлэлтийн байдал?	Баталгаатай гэр бүлтэй	1
		Салсан	2
		Огт гэрлээгүй	
		Хамтран амьдардаг	3
		Бэлэвсэн	4
		Гэр бүлээсээ тусдаа амьдардаг	5

2-р хэсэг : Өрхийн амьжиргааны байдал

201.	Та юунд амьдардаг вэ?	Өөрийн гэрт	1
		Өөрийн байшинд	2
		Түрээсийн гэрт	3
		Түрээсийн байшинд	4

		Нийтийн байранд	5
		Эцэг эхийн гэрт	6
		Бусад	7
202.	Та алт олборлооос гадна өөр ажил эрхэлдэг юу	Тийм	1
		Үгүй	2
203.	Хэрэв ажилладаг бол ямар төрлийн ажил эрхэлдэг вэ?	Улсын байгуулагад	1
		ТББ	2
		Хувиараа алт олборлодог	3
		Хувийн пүүс компани	4
		Хувиараа мал аж ахуй эрхэлдэг	5
		Гар дээрх наймаа	6
		Малчин	7
		Оюутан	8
		Бусад	9

204. Танай өрхийн орлогын эх үүсвэрүүд юу вэ? Сарын орлогоо тодорхойлно уу?

Орлогын эх үүсвэр	Код	Сарын орлого	Жилийн орлого
а. Цалин	1		
б. Тэтгэвэр	2		
в. Тэтгэмж	3		
г. Наймаа	4		
д. Газар тариалан (энэ хариултыг сонгосон тохиолдолд 208-р асуултыг асуух)	5		
е. МАА (энэ хариултыг сонгосон тохиолдолд 207-р асуултыг асуух)	6		
ё. Туслах а.а (таксиа, гахай гм)	7		
ж. Зээл тусламж	8		
з. Ах дүүгийн тусламж	9		
л. Эд хөрөнгө хөлсөлсөнөөс	10		
м. Алт олборлодог	11		
н. Бусад	12		
205 –ын хариулт: Нийт		-	-

205. Танай өрхийн нэг хүнд оногдох сарын орлого хэд вэ?

(нэг хүнд оногдох сарын орлого = өрхийн сарын орлого/ өрхийн ам бүлийн тоо)

206. Танай өрхийн нэг хүнд оногдох жилийн орлого хэд вэ?

(нэг хүнд оногдох жилийн орлого = өрхийн жилийн орлого/ өрхийн ам бүлийн тоо)

207. Хэрэв 204- р асуултын е-д хариулсан бол доорхи асуултыг асууна уу?

Танайд доорхи малнаас тус бүр хэдэн толгой малтай вэ?

1. Хонь
2. Ямаа
3. Үхэр
4. Тэмээ
5. Адуу

208. 204-р асуултын д-д хариулсан бол доорхи асуултыг асууна уу? Танайх хэдэн га газарт газар тариалан эрхэлдэг вэ?

209. Та хэдэн төрлийн хүнсний ногоо тарьдаг вэ?

210. Танайх хувьдаа өөрөө явагч тээврийн хэрэгсэлтэй юу?

- а. Тийм
- б. Үгүй

211. Тийм бол ямар тээврийн хэрэгсэлтэй вэ?

- а. Мотоцикл
- б. Суудлын автомашин
- в. Ачааны машин
- г. Том трактор
- д. Жижиг трактор (пад пад)
- е. Бусад

212. Танай өрх сард, жилд доорхи зүйлүүдэд ямар зардал гаргадаг вэ?

Зардлын төрлүүд	Код	Сараар	Жилээр
а. Хоол хүнс	1		
б. Хувцас	2		
в. Хичээлийн хэрэгсэл	3		
г. Сургалтын төлбөр	4		
д. Банкны өр зээл	5		
е. Малын тэжээл	6		
ё. Эрхэлж буй бизнесдээ	7		
ж. Эм тариа, эмчилгээний зардал	8		
з. Шатахуун тээврийн зардал	9		
л. Бусад	10		
Нийт		-	-

213. Танай өрх сардаа хэдэн төгрөг хадгалж чаддаг вэ?

- а. Огт хадгалж чаддагүй
- б. 1000 -10000
- в. 10 001- 20 000
- г. 20001-30000
- д. 30001-40000
- е. 40001-аас дээш

3-р хэсэг: Орон нутгийн харьяалал, шилжилт хөдөлгөөний талаарх мэдээлэл

301.	Та орон нутагт хэдэн жил амьдарч байна вэ?	Угуул оршин суугч	1
		3 – аас дээш жил	2
		1- 3 жил амьдарч байгаа	3
		1 хуртэл жил амьдарч байгаа	4
302.	Хэрэв та энд 3-аас бага жил амьдарч байгаа бол Жаргалант суманд албан ёсоор бүртгэлтэй юу?	Тийм	1
		Үгүй	2
303.	Хэрэв үгүй бол яагаад	Бүртгүүлэх шаардлагагүй гэж бодсон	1
		Энэ талаар тодорхой мэдээлэлгүй	2
		Иргэний үнэмлэх байхгүй	3
		Бусад холбогдох бичиг баримт байхгүй	4
		Хаашаа хэнд хандахаа мэддэггүй	5
		Ажил ихтэй завгүй байдаг	6
		Шилжүүлэг хийлгэх мөнгө байхгүй	7
		Бусад	8
304.	Ер нь ямар тохиолдолд бүртгүүлэх шаардлагатай гэж бодож байна	Эрүүл мэндийн тусlamж авах	1
		Яаралтай тусlamж авах	2
		Давхар ажил эрхлэх	3
		Энд суурьших	4
		Нийгмийн халамж	5
		Үйлчилгээ хүртэх	6
		Бусад	7

305.	Энд ирсэн шалтгаан	Алт олборлоо Бэлчээр хайж Ах дүү нараа бараадаж Илүү сайн сургууль үйлчилгээ хайж Ажиллах боломж хайж Бусад	1 2 3 4 5 6
------	--------------------	--	----------------------------

4-р хэсэг: Алт олборлолт буюу ажил эрхлэлтийн байдал

	Таны бодлоор мал аж ахуй эрхлэх нь алт олборлоос илүү ашигтай юу?	Алтны нөөц багасах Үйм УС, цахилгаангүй Хүчин ажиллаж байсан	1 1 2
	Тийм бол яагаад	Мөргөүүсээ эхийн дарамтуулах Дараалсан нийзээ зардаг Мөн тээврийн түүрүүртэй байх Сүрьеуль цэцэрэгтэй олдохгүй байх Нийгмийн хамамж үйлчилгээнд Бусад	1 2 3 4 5
	Үгүй бол яагаад	Нээснээсүүрийн арслан ширгийн чухаа буурч байгаа Мөхөн жижигийн байд алхамдхан зардаг учир ашиг Бөгөөд ялануулсан гадуурхагдах Ранын хамгаалын садарчийн учир тогтмол Дэмжээний байхадаггүй Бусад	1 2 3 4

Судлаач сонголтуудыг нэг бүрчлэн судалгаа өгөгчид уншиж өгөөд хамгийн хэцүү гэж тооцогдсон
3 асуудлыг 1-3 гэсэн рейтингээр үнэлэх (хамгийн том бэрхшээлд 1 гэсэн үнэлгээ өгөх)

411	Тэхийн санаар алшилбайр орух ажил эрхэлж байна вэ?	Баруун салаа Үүн Анаг Орлогого тогтмол өлдөг Бусад	1 1 2 1 3
	Тийм бол яагаад	Дархуурхаяадвар сайтай учир мөнгө Доргоход амар байдаг Ханш нь тогтмол байдаг Бусад	2 3 3
412	Тийм бол газрын зөвшөөрөлтэй юу? Зөшөөрөлтэй газрын хэмжээгээ хэлнэ үү?	Тийм Үүн Аль нас, эрүүл мэндэд аюултай	1 1
413	Та алт олборлох ажлаа орхиод Үүгүй бол яагаад Өөр ажил эрхэмлээр байна уу?	Хялтгайтай мөнгө олон Алт олдохгүй төхмөндөл их байдаг Эрүүл мэнд муудсан Хорилалт замбаргаагүй байдал их байдаг Алсан уурхай газраасаа хөөсөн Алтны нийтээгээ гарзар ховор Рүүлийн параметрүүдийн хувь Газар ажиллаж чаддаггүй Бусад	1 1 2 3 3 4 5 6 6
414	Та яагаад өөр ажил эрхлэх Сонирхолтой байна вэ?	Гэр бүлээсээ хол Алтанаа барьж чадахгүй	8 9
	Та хэдэн жил алт олборлож байна вэ	Алтны гарц муу Бусад	10 11
416	Хангалттай мөнгөтэй болсон вэ? тохиолдолд яж зарцуулах сонирхолтой байна вэ?	Махишидээж байжтын төлбөр төлөх Ниймаад хийх Хийвэрээрээ болох Хийвэрээрээ төлөх Зээлдүүлэх Зүйнгээнд зарцуулах Ахуйн хэрэглээ Бусад	1 2 3 3 4 5 6
417	Та жилийн ямар улиралд алт олборлох ажлыг ихэвчлэн хийдэг вэ?	Өвөл Хөдөлж олох өөр боломжгүй болсон Визнес эрхлэх мөнгө олохын тулд Намар Бусад	1 6 3 4 5
418	Алт олборлох ажил эрхлэхэд Та хоногт дунджаар хэдэн цаг таны хамгийн түүрүүд	Уурхай дээр байр, орон сууц олдожгүй байх Газрын зөвшөөрөл олдохгүй байх	5

	ажилладаг вэ	Ханцуйч	5
	Та долоо хоногт дунджаар хэдэн Хоног амардаг вэ?	Ажиллах нийгмийн комбинзон Хоногийн комбинзон Ауваджидер Бэхжилэш өдөр Дажалнаани олс Хормогийн цаг агаар таагуй уед л амардаг	6 2 3 9 50 61
	Ажиллахад хамгийн хэцүү цаг агаарын нөхцөл байдал юу вэ?	Хамгаалах нийгмийн Магнитнуудын байх Русад	12 13 14
428	Энэ хувцаснуудаас хамгийн их Хэрэгцээтэй нь юу вэ?	Каск Бэлли Макс Бусад	4 5 3 8
	Та яг ямар төрлийн ажил гүйцэтгэдэг вэ?	Хошуувч Оухуах Линнуувч Дордо зөөх, шигших Хоногийн комбинзон Алтаяа угаах/резиндэх Ажлын энгийн комбинзон Гэзэнгээ хийх Нийтийн Нийтийн бутлах/ хайраглах Агааржууллагч Мөнгөн усаар бариулах Бэхжилээний блс Ус зөөх Хөрмөгүү Шороо хурздэж барх Хамгаалах нийгмийн шил Мусад Мангайтай цамц НУХ ухах Русад	4 5 6 7 8 9 10 11 12 13 14
431	Эдгээр ажлуудаас эмэгтэйчүүд ямар ажлыг нь голдуу хийдэг вэ?	Хөвөд Алтаяа угаах/резиндэх Нөөм Часалгээ хийх Хувийн бутлах/ хайраглах Хувийн Мөнгөн усаар бариулах Ус зөөх Шороо хурздэж өгөх Бусад	1 2 3 4 5 6 7 8
	Эдгээр ажлуудаас хамгийн хэцүү ажил нь аль вэ?	Хийн, газар хөлдсөн уед нүх ухах Хас хайлсан дараа буюу борооны дараа Хуудасын уед нүх ухах	10 11 12
432	Ямар багаж таны хөдөлмөрийг илүүтэйгээр хөнгөвчилж өгдөг вэ?	Хүчинээс сул өргөж шороог гаргах Хийтанд алтаяа угаах/ резиндэх Алтаяа угаах/ резиндэх Хувийн бутлах/ хайраглах Ус зөөх Шородажурздэж өгөх Бусад	4 5 6 7 8 9 10
	Та өдөрт хэдэн цаг газар дор ажилладаг вэ?	Санар доор ажилладаггүй Узаан доор ажилладаг (цаг)	8 9
	Та өдөрт хэдий хэмжээний шороо угаадаг вэ?	Мэдэгдэг Хүчийн (гаагрэ = 3кг)	10 21
	Танд ажлын дараах нөхцлөөс	Бусад	12
433	Ханд хөдөлжиртэй наасуудыг хувцас хэрэгсэл ашиглахтай холбоотой ямар хүндрэл гардаг вэ?	Ямар хувцас хэрэгсэл хэрэглэхийг мэддэггүй Хөнжүүлдэггүй Хэзээ чадах Хувийн чадахаа мэддэггүй Хэрэгхүү сонирхолгүй Агаарчүүий Мөнччүүий Биччүүий Ямар ч хувцас хэрэгсэл аюулгүй байдлыг Бусад	2 2 3 4 5 6 7 8 9 10
	Та ажиллах үедээ эдгээр Хувцас, хэрэгслүүдээс хэрэглэдэг юу?	Каск Бэлли Макс Хошуувч	1 2 3 4

5-р хэсэг: ХАМО иргэний орлого, зарлагын байдал

#	Асуулт	Алтны хэмжээ (грамм)	Мөнгөн орлого (төгрөг)
501	Та өдөрт дунджаар хэдий хэмжээний алт олборлодог вэ?		
502	Та долоо хоногт дунджаар хэдий хэмжээний алт олборлодог вэ		
503	Та сард дунджаар хэдий хэмжээний алт олборлодог вэ?		
Судлаач нэг өдөр, долоо хоног, нэг сарын дундаж дээр үндэслэн сарын дундаж орлогыг хооронд харьцуулан шалгах, үүн дээрээ үндэслэн тухайн ХАМО иргэний жилд олборлодог алтны хэмжээ, төгрөгт шилжүүлсэн орлогын хэмжээг тооцоолон гаргах			
504.	Жилд олборлодог дундаж алтны хэмжээ		
505.	Жилийн алтнаас олох орлого		
506	Та алт олборлож эхэлснээсээ хойш хамгийн их нь хэдий хэмжээний алт олборлож байсан бэ?		
507	Өдөрт алт олборлохын тулд хэдэн төгрөгний зардал гаргадаг вэ?		
508	Долоо хоногт алт олборлохын тулд хэдэн төгрөгний зардал гаргадаг вэ?		

509. Та алт олборлоход хэдий хэмжээний зардлыг, аль улирлуудад гаргадагаа хэлнэ үү?

Зардлын төрөл	Өвөл	Хавар	Зун	Намар
а. Багаж, тоног төхөөрөмж хэрэгсэл худалдан авах				
б. Багаж, тоног төхөөрөмж түрээслэх				
в. Ажлын хувцас, бээлий				
г. Аюулгүй ажиллагааны хэрэгсэлд				
д. Хоол хүнс				
е. Байр				
ё. Унаа тээвэр				
ж. Газар гэсгээх бензин				
з. Газар гэсгээх түлээ				
л. Усны зардал				
м. Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл				
н. Бусад				
Нийт				

510. Жилийн нийт зарлага нь хэд болох? (өв/з+зун/з+хав/з+нам/з=жилийн нийт зардал)

..... төг

511. Жилийн цэвэр ашгийг ойролцоогоор хэд вэ?

(Цэвэр ашиг = 505-р асуултын хариугаас – 510-р асуултын хариу)

..... төг

512	Та алт орлогоосоо мөнгөн хуримтлал үүсгэсэн үү?	Тийм	1
		Үгүй	2
513	Тийм бол та мөнгөн хуримтлалаа хаана хадгалдаг вэ?	Арилжааны банк	1
		Зээлдүүлдэг	2
		Гэрлүүгээ явуулдаг	3
		Эндээ хадгалдаг	4
		Бусад	5

514	Та алт олборлож эхэлснээс хойш зээл авсан уу?	Тийм Үгүй	1 2
515	Ямар зорилгоор зээл авсан бэ?	Ахуйн хэрэгцээндээ Хүүхдийн сургалтын төлбөр Багаж тоног төхөөрөмж авах Үүлын ажил эрхлэхийн тулд Өрөө төлөх Бусад	1 2 3 4 5
516	Одоо зээлтэй байгаа юу?	Тийм Үгүй	1 2
517	Одоо та ойролцоогоор хэдэн төгрөгний зээлтэй байгаа вэ?		
518	Та олборлосон алтаа хэрхэн борлуулдаг вэ?	Гэр дэлгүүрт Том компанид Хот эсвэл аймагт очиж борлуулдаг (хувь хүн) Банк Газар дээр нь алтны монгол ченжид Гадаадын хүнд Бусад	1 2 3 4 5 6
519	Та орлогоосоо хамгийн их мөнгөө зөрцуулдаг зүйл тань юу вэ	Хүүхдийн сургалтын төлбөр Гэр бүлээ тэжээх Амьдралаа дээшлүүлэх Орон гэртэй болох Унаа тэрэгтэй болох гэж Бусад	1 2 3 4 5 6
520	Та алтнаас олж буй орлогодоо хэр зэрэг сэтгэл хангалуун байдаг вэ?	Сэтгэл хангалуун Дунд зэрэг Хангалуун биш	1 2 3

6-р хэсэг: ХАМО иргэдийн эрүүл мэндийн байдал ба эрүүл мэндийн үйлчилгээ

601	Та ихэвчлэн хаанахын эмнэлгээр үйлчлүүлдэг вэ?	Түргэн тусламж Улсын клиник Аймгийн эмнэлэг Сумын эмнэлэг Хувийн эмнэлэг Уурхайн, Багийн эмнэлэг Бусад	1 2 3 4 5 6 7 8
602	Та өвдсөн үедээ ихэвчлэн хэнд ханддаг вэ?	Их эмч Бага эмч, Сувилагч Эрүүл мэндийн сайн дурын ажилтан Бариач Лам Гэр булийнхэн Найз нөхөд төрөл садан Бусад	1 2 3 4 5 6 7 8 9
603	Та ихэвчлэн ямар төрлийн эрүүл мэндийн тусламж авдаг вэ?	Яаралтай т үргэн тусламж дуудах Сум, өрхийн эмчид хандах Нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх Рашаан, сувилалд амрах Эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх Дархлаажуулалт хийлгэх Бусад	1 2 3 4 5 6 7
604	Танд алт олборлох ажил эрхэлснээс хойш ямар нэг өвчний зовиур илэрсэн үү?	Чих шуугих Ханиах Нүд үрэвсэх, улайх, нулимс гоожих Арьс загатнах, тууралт гарах	1 2 3 4

		Хавагнах	5
		Гэдэс дотор эвгүйрэх	6
		Шээс ойрхон хүрэх	7
		Ууц нуруугаар өвдөх	8
		Үе мөч өвдөх	9
		Цээжээр хатгуулан, ханиалгах	10
		Зовиур илрээгүй	11
		Бусад	12
605	Танд эрүүл мэндийн тусламж авахад тулгардаг бэрхшээл бий юу?	Эрүүл мэндийн тусламж авах зай хол	1
		Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй	2
		Орон нутгийн харьяалалгүй	3
		Холбоо харилцаа хангалтгүй	4
		Тээврийн хэрэгсэл дутмаг	5
		Мөнгөгүй	6
		Бэрхшээлгүй	7
		Бусад	9
606	Та алт олборлох хугацаандаа осол гэмтэлд өртсөн үү?	Тийм	1
		Үгүй	2
607	Тийм бол та хэдэн удаа осол гэмтэл авч байсан бэ?	1-2 удаа	1
		3-4 удаа	2
		5-аас дээш	3
608	Хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой ямар осол гэмтэлд орж байсан бэ?	Шороонд дарагдсан	1
		Бэхэлгээний олс тасарсан	2
		Нүхэнд унасан	3
		Тэсэлгээнд өртсөн	4
		Түлэгдсэн	5
		Угаартсан	
		Гэмтэл аваагүй	6
		Бусад	7
609	Сард ойролцоогоор хэдэн удаа осол гардаг вэ?		
610	Тэгвэл ихэвчлэн ямар төрлийн осол аваар гардаг вэ?	Шороонд дарагдах	1
		Бэхэлгээний олс тасрах	2
		Нүхэнд унах	3
		Түлэгдэх	4
		Угаартах	5
		Бусад	6
611	Шаардлагатай эм, тариагаа хаанаас авдаг вэ?	Гэр дэлгүүр	1
		Өөрт байдаг	2
		Хувь хүн	3
		Сумын төвөөс	4
		Бусад	5
612	Осол аваарын гол шалтгааныг та юу гэж боддог вэ?	Аюулгүй ажиллагааны журмыг мэдэхгүйгээс	1
		Аюулгүй ажиллагааны журмыг мэддэг ч амьдралд хэрэгжүүлдэггүйгээс	2
		Газрын хөрс зөөлөн нурамхай учраас	3
		Хөдөлмөр хамгааллын багаж хэрэгсэл дутмагаас	4
		Хайхрамжгүй байдлаас болж	5
		Цаг агаарын нөхцөл байдлаас болж (үер, хүйтэн байх г.м.)	6
		Газар гэсгээх шаардлагын улмаас	7
		Бусад	8
613	Та ямар хугацаанд хамгийн ойр байдаг эмнэлгийн тусламжийг авах боломжтой байдаг вэ?	2 цаг хүртэлх	1
		2-12 цаг	2
		12-24 цаг	3
		3 хоногоос дээш хугацаанд	4
614	Та эрүүл мэндийн даатгалд хамрагдсан уу	Тийм	1
		Үгүй	2

615	Хамрагдсан бол энэ жилийн даатгалын хураамжaa төлсөн үү?	Тийм	1
		Үгүй	2
616	Үгүй бол та яагаад эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй вэ?	Ямар нэг ажлын газрын харьяалалгүй	1
		Мөнгөний боломжгүй	2
		Бүртгэл, бичиг баримтгүй	3
		Надад хэрэггүй	4
		Мэдэхгүй	5
		Бусад	6

7-р хэсэг: Нийгмийн даатгалд хамрагдалт ба нийгмийн халамж үйлчилгээ

701	Та алтнаас олсон орлогоосоо нийгмийн даатгал төлдөг үү?	Тийм	1
		Үгүй	2
702	Үгүй бол ямар шалтгаанаар төлдөггүй вэ?	Төлбөрийн чадваргүй	1
		Төлөх аргаа мэдэхгүй	2
		Даатгалын байгууллагын ажилтантай уулзаж чаддагчгүй	3
		Нийгмийн даатгалд даатгуулахыг Хүснэггүй	4
		Завгүй	5
		Бусад	6
703	Нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдлыг та юу гэж боддог вэ?	Тэтгэвэр	1
		Тэтгэмж	2
		Осол гэмтлийн даатгал	3
		Мэдэхгүй	4
		Бусад	5
704	Танд одоо нийгмийн халамжийн ямар үйлчилгээ шаардлагатай байна вэ?	Өндөр настны тэтгэвэр	1
		Хүүхэд асарсны тэтгэмж	2
		Тахир дутуугийн тэтгэмж	3
		Нэн ядуу иргэдийн тэтгэмж	4
		Тэжээгчээ алдсаны тэтгэмж	5
		Шинээр гэр бүл болсны	6
		Хүүхдийн тэтгэмж	7
		Хэрэггүй	8
		Бусад	9
705	Та алтнаас олсон орлогоосоо Орлогын албан тавар төлдөг үү?	Тийм	
		Үгүй	
707	Тийм бол сард хэдэн төгрөг татвар төлдөг вэ?		
707	Үгүй бол ямар шалтгаанаар төлдөггүй вэ?	Төлбөрийн чадваргүй	1
		Төлөх аргаа мэдэхгүй	2
		Энэ талаарх мэдээлэл байхгүй	3
		Завгүй	4
		Бусад	5

8-р хэсэг: ХАМО иргэдийн зохион байгуулалт, хамтын ажиллагаа

801	Та нөхөрлөлийн тухай сонссон үү?	Тийм	1
		Үгүй	2
802	Та нөхөрлөлийн гишүүн мөн үү?	Тийм	1
		Үгүй	2
803	Та ямар нөхөрлөлийн гишүүн бэ? (нэрийн бичих)		
804	Та нөхөрлөлөд ороод хэр удаж байгаа вэ	0-3 сар	1
		4-12 сар	2
		12-аас дээш	3
805	Танай нөхөрлөл хэдэн гишүүнтэй вэ?		
806	Нөхөрлөл орохын давуу тал юу вэ?	Хөдөлмөр хөнгөвчилдөг	1

		Багаж хэрэгслээ хувааж ашигладаг	2
		Аюулгүй байдал сайжирдаг	3
		Орлого нэмэгддэг	4
		Мэдээлэл сайн авдаг	5
		Нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдахад дөхөмтэй байдаг	6
		Алт олборлох газартай болдог	7
		Асуудлаа хамт олноороо шийддэг	8
		Асуудлаа дэвшүүлэхэд амар, хүчтэй байдаг	9
		Бусад	10
807	Нөхөрлөлийн гишүүдийн хувьд ашгаа хэрхэн хуваадаг вэ	Тэгш хуваадаг Хийснээрээ авдаг Нөхөрлөлийн ахлагч хуваарьладаг Ярилцаж байж шийддэг Бусад	1 2 3 4 5
808	Нөхөрлөлийн гишүүдийн ашгаа хувааж байгаа байдалд та хэр сэтгэл хангалуун байдаг вэ?	Сэтгэл хангалуун Сэтгэл дундуур Сэтгэл хангалуун биш	1 2 3
809	Танай нөхөрлөл алт олборлох газрын албан ёсны зөвшөөрөлтэй юу?	Тийм Үгүй	1 2
810	Тийм бол хэдэн га газрын зөвшөөрөлтэй вэ?	Газрын хэмжээг бичих: Мэдэхгүй:	
811	Нөхөрлөлд ороогүй бол яагаад?	Нөхөрлөлийн талаар сайн мэдэхгүй Нөхөрлөлд ороход өндөр шаардлага тавигддаг Санаа нийлсэн хүмүүс байхгүй Нөхөрлөлд ороод хэрэггүй, ашиггүй гэж үздэг Ашгаа хуваах тал дээр асуудалтай Бусад	1 2 3 4 5 6
812	Байдрагийн хөгжил ТББ-ийн талаар мэдэх үү?	Тийм Үгүй	1 2
813	ТББ юу хийдэг вэ?	Сургалт явуулдаг ХАМО эрх ашгийг хамгаалдаг Нөхөрлөл бий болгоход тусладаг ХАМО иргэдийн оролцоог дэмждэг ХАМО ажлын байрын аюулгүй байдалд анхаардаг ХАМО иргэдийн тулгамдаж байгаас асуудлыг шийдүүлэхийн төлөө ажилладаг ХАМО-ыг зохин байгууллатайгаар, эмх цэгцэйгээр алт олборлоход го үүрэг гүйцэтгэдэг Мэдээллээр хангадаг Мэдэхгүй Сонссон боловч, үйл ажиллагааг нь сайн мэдэхгүй Бусад	1 2 3 4 5 6 7 8 9 10 11
814	Таны байгаа газар хамгийн их хэрэгцээтэй зүйл юу байна вэ	Тогтмол хэвлэл Халуун ус Цахилгаан Үндны ус Чөлөөт цагаа өнгөрөөх газар Банкны үйлчилгээ Эмнэлэг Сургууль Цэцэрлэг Даатгалын үйлчилгээ /осол, тэтгэмжийн даатгал/ Үзвэр үйлчилгээ Жорлон	1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12

		Бусад	13
815	Таны эрх ашгийг ямар байгууллага хамгаалдаг гэж та боддог вэ?	Их хурлын гишүүн	1
		Аймгын засаг захиргааны байгууллага	2
		Сумын засаг захиргааны байгууллага	3
		Уул Уурхайн аврах алба	4
		Бичил Уурхай төсөл	5
		Байдрагийн Хөгжил ТББ	6
		Нөхөрлөл	7
		Улс төрийн намууд	8
		Иргэний нийгмийн хөдөлгөөнүүд	9
		Бусад (нэрийг нь бичих)	10

ХАВСРАЛТ 6

Чанарын судалгааны зорилтот бүлгүүд:

A. Бүлгийн ярилцлага

1. Хувиараа алт олборлогч эрэгтэйчүүдийн бүлэг
2. Хувиараа алт олборлогч эмэгтэйчүүдийн бүлэг

B. Ганцаарчилсан ярилцлага

1. Жаргалант сумын засаг дарга болон багийн засаг дарга
2. Сумын нийгмийн ажилтан
3. Сумын хэсгийн төлөөлөгч
4. Сумын эмнэлгийн эмч
5. Сумын байгаль орчны байцаагч
6. Сумын дэлгүүрийн эзэд / Байдрагийн Зүүн Баруун салаанд ажиллаж байгаа дэлгүүрийн эзэд
7. Жаргалант сум дахь “Жамп” ХХК-ны удирдах ажилтан
8. Баянхонгор аймгийн мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч
9. Хувиараа алт олборлогч иргэн
10. Жаргалант сум дахь ХААН банкны удирдах ажилтан

Бүлгийн ярилцлага явуулах удирдамж, гол асуултууд

Зорилтот бүлэг:1	Гар аргаар алт олборлогч эрэгтэйчүүд
Зорилтот бүлгийн дундаж нас:	18-50
Оролцогчдын тоо:	20-25
Бүлгийн ярилцлагын зорилго:	Хувиараа алт олборлож байгаа эрэгтэйчүүдийн хувьд нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал, эрүүл мэнд, ажлын байрын аюулгүй, хөдөлмөр хамгааллын байдал, тэгш оролцоо ямар байгаа тухай болон тэдний нийгмийн халамж, үйлчилгээг хүртэхэд тулгарч буй бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замын талаарх санал бодол, хандлагыг тодруулах ярилцлага хийх.

Танилцах

1. Судлаач өөрийгөө танилцуулна
2. Ярилцагчийн овог, нэр, хаягийг асууж, оролцогчдыг санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх уур амьсгалыг бүрдүүлнэ
3. Судалгааны зорилгыг танилцуулна.
4. Ярилцагчийн шилжин суурьшилт эсвэл хувиараа алт олборлохтой холбоотой байгаа нөхцөл байдал, хүндрэл бэрхшээлүүдийн талаар санаа, бодол, хандлагыг сонсох хүсэлтэй байгаагаа илэрхийлнэ.

Ярилцлага хөтлөгчийн анхаарах зүйл:

Ярилцлагаа эхлэх үед:

1. Судлаач хариулахад хялбар, энгийн асуултыг асууна.
2. Ярилцлагыг цаашид өрнүүлэх асуултыг асууна.
3. Ярилцлагыг гүнзгийрүүлэх
4. Ярилцлага хийх сэдвийн гол асуултыг асууж ярилцана
5. Ярилцагчаас тийм, үгүй гэсэн хариулт өгөх асуулт асуухаас зайлсхийх.
6. Судлаач ярилцагчид нөлөө үзүүлж болохуйц санаа өгөх, өөрийн санаа, бодлыг тулгахыг хориглоно.

Ярилцлагын төгсгөлд:

1. Ярилцлагын үр дүнгийн хяналтын хуудсыг шалгаж, орхигдуулсан асуулт байвал асууна.
2. Судлаач ярилцагчийн хэлсэн үгийн ярилцлагын тэмдэглээс түүний санаа, бодлыг нэгтгэн танилцуулна.
3. Ярилцлагын явцад гарсан ойлгомжгүй хэллэг, санаа болон хоёрдмол утгатай санааг тодруулан асууж болно.
4. Ярилцлага өгөгчид манай судалгаанд амжилттай оролцож, өөрийн санал бодлыг илэрхийлсэнд талархал илэрхийлж, түүний санаа, бодол эдгээр хүндэрэл, бэрхшээлийг шийдвэрлэхэд тодорхой хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байгаагаа хэлж, ярилцлагыг төгсгөнө.

Гол асуултууд:

1. Та нарын хувиараа алт олборлох шалтгаан юу вэ? Яагаад уламжлалт мал аж ахуй, газар тариалангагаа эрхлэлгүй алт олборлолтыг сонгосон бэ?
2. Та алт олборлохоосоо өмнө ямар ажил хийдэг байсан бэ?
3. Танай гэр булийн гишүүдээс хэдэн хүн энд алт олборлож байна вэ?
4. Та яг ямар ажил үүрээс гүйцэтгэдэг вэ? /Нүх үхдаг уу, шороогго гаргадаг уу, шороогго угаадаг уу, зардаг уу/
5. Хамгийн хүнд ажил нь юу вэ? Энэ ажлыг хэдэн насны, бие бялдарын хувьд ямар хүмүүс хийдэг вэ?
6. Хамгийн их үнэлгээтэй ажил нь юу вэ?
7. Өдөрт хэдэн цаг ажилладаг вэ? Өөрийн ажлын нөхцөл байдлаа та ямар гэж үнэлэх вэ?/ маш хүнд, хүнд, хүндэвтэр
8. Өдөрт хэдий хэмжээний алт олборлодог вэ? Үүнийг мөнгөөр илэрхийлвэл хэдэн төгрөгний орлоготой байдаг вэ?
9. Хэдэн хүн нийлж нэг бригад/ нөхөрлөл болж ажилладаг вэ? Орлогоо хэрхэн хуваадаг вэ?
10. Алтаяа хэнд, хаана зардаг вэ?
11. Алтаяа хаана, хэнд хамгийн үнэтэйгээр зарж болох вэ?
12. Алт зарахад ямар зохицуулалт байгаасай гэж хүсдэг вэ?
13. ХАМО нарын эрүүл мэндийн байдал ямар байдаг вэ? Тэдний дунд нийтлэг тохиолддого ямар өвчин байдаг вэ?
14. Өөрийн аюулгүй байдлаа хэрхэн хангадаг гэж өөрийгөө үздэг вэ?
15. Аваар осол хэр зэрэг олон гардаг вэ? Ямар төрлийн ослууд илуутэй гардаг вэ?
16. Осол гарсан үед хэнд, хэрхэн хандаж тусламж авч байсан бэ? Та түүнд хэрхэн тусалсан бэ? Эмнэлгийн тусламж дунджаар хэдий хугацааны дотор ирж байсан бэ?
17. Та эрүүл мэндийн даатгалын дэвтэртэй юу? Энэ жил даатгалаа төлсөн үү?
18. Цаашид аваар ослоос хэрхэн урьдчилан сэргийлье гэж боддог вэ?
19. Энэ газрын алтны нөөцийг та юу гэж үнэлэх вэ? Эндэхийн нөөц дууссан тохиолдолд та яах вэ?

Зорилтот бүлэг:2	Хувиараа алт олборлогч эмэгтэйчүүд
Зорилтот бүлгийн дундаж нас:	18-50
Оролцогчдын тоо:	20-25
Бүлгийн ярилцлагын зорилго:	Хувиараа алт олборлож байгаа эмэгтэйчүүдийн хувьд нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал, эрүүл мэнд, ажлын байрын

	аюулгүй, хөдөлмөр хамгааллын байдал, тэгш оролцоо ямар байгаа тухай болон тэдний нийгмийн халамж, үйлчилгээг хүртэхэд тулгарч буй бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замын талаарх санал бодол, хандлагыг тодруулах ярилцлага хийх.
--	--

Гол асуултууд:

1. Та бүхэн энд хэр удаан алт олборлож байна вэ?
2. Та нарын хувиараа алт олборлох шалтгаан юу вэ? Яагаад уламжлалт мал аж ахуй, газар тариалангаа эрхлэлгүй алт олборлолтыг сонгосон бэ?
3. Та алт олборлохоосоо өмнө ямар ажил хийдэг байсан бэ?
4. Танай гэр бүлийн гишүүдээс хэдэн хүн энд алт олборлож байна вэ? Хэн хэн таньтай хамт алт олборлодог вэ? Таныг алтаа олборлож байх хугацаанд хүүхдүүдийг тань хэн хардаг вэ?
5. Эмэгтэйчүүд алт олборлоход чухам ямар ямар ажлуудыг хийж байна вэ?
6. Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн ажил үүргийн ялгаа алт олборлоход байдаг уу?
7. Та яг ямар ажил үүрэг гүйцэтгэдэг вэ? /Нүх ухдаг уу, шороогоо гаргадаг уу, шороогоо угаадаг уу, зардаг уу, хоол хийдэг уу/
8. Эмэгтэй хүний хувьд хамгийн хүнд хэцүү зүйл нь юу вэ?
9. Өдөрт хэдэн цаг ажилладаг вэ? Өөрийн ажлын нөхцөл байдлаа та ямар гэж үнэлэх вэ?/ маш хүнд, хүнд, хүндэвтэр
10. Өдөрт хэдий хэмжээний алт олборлодог вэ? Үүнийг мөнгөөр илэрхийлвэл хэдэн төгрөгний орлоготой байдаг вэ?
11. Хэдэн хүн нийлж нэг бригад/ нөхөрлөл болж ажилладаг вэ? Орлогоо хэрхэн хуваадаг вэ? Эмэгтэй хүний хөдөлмөрийг багаар үнэлж, бага орлого хуваах явдал байдаг уу?
12. Жирэмсэн эмэгтэйчүүд болон бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүд хэр олон ажилладаг вэ?
13. Та эрүүл мэндийн байдлаа хэрхэн үнэлдэг вэ? Ямар өвчлөл их байдаг вэ?
14. Өөрийн аюулгүй байдлаа хэрхэн хангадаг гэж өөрийгөө үздэг вэ? Ямар нэгэн осол аваарт орж байсан уу?
15. Аваар осол хэр зэрэг олон гардаг вэ? Ямар төрлийн ослууд илүүтэй гардаг вэ?
16. Осол гарсан уед хэнд, хэрхэн хандаж тусламж авч байсан бэ? Та түүнд хэрхэн тусалсан бэ? Эмнэлгийн тусламж дунджаар хэдий хугацаан дотор ирж байсан бэ?
17. Та эрүүл мэндийн даатгалын дэвтэртэй юу? Энэ жил даатгалаа төлсөн уу? Даатгал ямар уед хэрэгтэй гэж та боддог вэ?
18. Цаашид аваар ослоос хэрхэн урьдчилан сэргийлье гэж боддог вэ?
19. Энэ газрын алтны нөөцийг та юу гэж үнэлэх вэ? Эндэхийн нөөц дууссан тохиолдолд та яах вэ?

**Жаргалант сумын засаг дарга болон багийн засаг дарга
нартай хийх ганцаарчилсан ярилцлага № 1****Үргэлжлэх хугацаа:**

45 минут

Шаардагдах зүйл:

дуу хураагуур, тэмдэглэл хөтлөх цаас, үзэг, тэмдэглэл хөтлөгч

Гол асуултууд:

Сумын засаг даргын тамгын газраас алт олборлогчдоо үзүүлэх нийгмийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа

1. Танай суманд хэдэн ХАМО иргэд байдаг вэ? Өөр ямар аймаг сумдаас хүмүүс ирж алт олборлодог вэ?
2. Танай суманд хэдэн газарт иргэд хувиараа алт олборлож байна вэ?
3. Танай суманд албан ёсны газрын зөвшөөрөлтэй хэдэн нөхөрлөл байдаг вэ? Эдгээр нөхөрлөлд ойролцоогоор хэдэн хүн хамрагддаг вэ?
4. Хувиараа алт олборлож байгаа иргэдийн орон нутгийн эдийн засгийн хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг та хэрхэн үнэлэх вэ?
5. Хувиараа алт олборлох үйл ажиллагаанаас суманд жилд хэдий хэмжээний орлого орж байгаа гэж боддог вэ? Тэгвэл мал аж ахуйгаас жилд хэдэн төгрөгний орлого олдог вэ?
6. Танай суманд хувиараа алт олборлож буй иргэдийн асуудлаар Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, сумын засаг даргын тамгын газраас ямар бодлого, чиглэл барьж ажилладаг вэ?

7. Хувиараа алт олборлогч иргэдэд сумаас нийгмийн ямар тусламж, үйлчилгээг үзүүлж байгаа вэ?
8. Танай суманд ХАМО иргэдийн алт олборлох үйл ажиллагаатай холбоотой осол аваар жилд ойролцоогоор хэд гардаг вэ? Осол аваар гаралтад буурах хандлага байна уу?
9. Хувиараа алт олборлогчдын шилжилт хөдөлгөөний бүртгэл, суурьшилтын тогтолцоог боловсронгуй болгох талаар та ямар саналтай байдаг вэ?
10. Хувиараа алт олборлогч иргэдээс болж төрийн үйлчилгээний байгууллагаудын ачаалал нэмэгддэг гэж та боддог уу? Жишээ нь эмнэлэг, цагдаа хуулийн байгууллага гэх мэт

Алт олборлогчдын зүгээс суманд учруулж буй сөрөг нөлөөлөл

11. Танай сумын нутагт иргэд хувиараа алт олборлосноос болж байгаль орчинд ямар сөрөг нөлөөлөл гарч байна вэ?
12. Сөрөг нөлөөллийг том уурхайтай харьцуулахад их үү бага уу?
13. Мөн энэхүү сөрөг нөлөөллийг бууруулах тал дээр та ХАМО иргэдтэйгээ хамтран юу хийж байна вэ?
14. Алт олборлосон газраас хэдэн газарт нөхөн сэргээлт хийгдсэн бэ? Хувиараа алт олборлогчид нөхөн сэргээлт хийсэн газрын хэмжээг та тусад нь хэлж өгнө үү?
15. Танай сумын үндсэн иргэд ба гаднаас ирж алт олборлож байгаа хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулахад сумын захиргаанаас ямар арга хэмжээ авах нь зүйтэй гэж та бодож байна вэ?
16. Хувиараа алт олборлогчдын үйл ажиллагаа, газрын асуудлыг зохицуулж буй дүрэм, журмыг боловсронгуй болгох талаар та ямар санал бодолтой байна вэ?

Жаргалант сумын нийгмийн ажилтантай хийх ганцаарчилсан ярилцлага №2

Үргэлжлэх хугацаа:

45 минут

Шаардагдах зүйл:

дуу хураагуур, тэмдэглэл хөтмөх цаас, үзэг, тэмдэглэл хөтмөлгч

Гол асуултууд:

1. Танай суманд ХАМО иргэд хэд байдаг вэ? Тэдний хувиараа алт олборлох болсон шалтгааныг та юу гэж боддог вэ?
2. Танай сумын иргэдийн хэдэн хувь нь нэн ядуу, ядуу, дундаж, чинээлэг иргэд байдаг вэ?
3. Танай сумын өрхийн хэдэн хувь нь хувиараа алт олборлох үйл ажиллагаанд оролцож байна гэж үздэг вэ? Тэдний хэдэн хувь нэн ядуу, ядуу, дундаж, чинээлэг иргэд байдаг вэ?
4. Танай сумын нийт эмзэг бүлгийн иргэдийн хэдэн хувь нь зөвхөн алтнаас хамааралтай амь зуух байна вэ?
5. Өөр аль аймаг сумдаас хэдэн ХАМО иргэд ирж алт олборлож байна вэ?
6. Гаднаас ирсэн ХАМО нар болон нутгийн иргэдийн хооронд ямар нэгэн зөрчил үүсдэг үү? Үүсдэг бол гол шалтгаан нь юу вэ?
7. Хувиараа алт олборлогч иргэдийн дунд нийгмийн ямар тулгамдсан асуудал байна вэ? /Архидалт, хүчин, биеэ үнэлэлт, танхай/
8. Ажилгүйдэл хэдэн хувьтай вэ?
9. Сургууль завсардалт хэдэн хувьтай байдаг вэ? Гол шалтгаан нь юу вэ?
10. Орон нутгийнхаа нэн ядуу, ядуу, дундаж, чинээлэг айл өрхүүдийг та юу гэж тодорхойлох вэ?
 - a. Орлого
 - b. Малын тоо
 - c. Гэр орны байдал
 - d. Ажил мэргэжил, бизнес эрхэлж буй байдал
 - e. Ам булийн тоо, хүүхдийн тоо
 - f. Газар
 - g. Унаа тэрэг
 - h. Эрүүл мэнд гэх мэт
11. Ганц бие өрх толгойлсон эмэгтэйчүүд/ эрэгтэйчүүд хэр олон байдаг вэ? Тэдэнд алт олборлон амьжиргаагаа залгуулах, дээшлүүлэх боломж хэр байдаг гэж та боддог вэ?
12. Хувиараа алт олборлогч иргэдэд сумаас нийгмийн ямар тусламж, үйлчилгээг үзүүлж байгаа вэ?
13. Хувиараа алт олборлогчдын шилжилт хөдөлгөөний бүртгэл, суурьшилтын

- тогтолцоог боловсронгуй болгох талаар та ямар саналтай байдаг вэ?
14. Нийгмийн халамж хамгаалал, нийгмийн даатгал зэрэг асуудлуудын талаар хувиараа алт олборлож буй үргэдийн дунд та өөрийн зүгээс сургалт сурталчилгааны ажлуудыг хийж байсан уу? Аль чиглэлээр, хэрхэн хийж байсан бэ?
15. Таны бодлоор хувиараа алт олборлож байгаа үргэдийн тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд ямар үйл ажиллагааг зохион байгуулбал дээр гэж боддог вэ?

Жаргалант сумын хэсгийн төлөөлөгчтэй хийх ганцаарчилсан ярилцлага № 3

Үргэлжлэх хугацаа:

45 минут

Шаардагдах зүйл:

дуу хураагуур, тэмдэглэл хөтлөх цаас, үзэг, тэмдэглэл хөтлөлгч

Гол асуултууд:

1. Танай суманд ямар төрлийн гэмт хэрэг зөрчлүүд ихэвчлэн гардаг вэ?
2. Гэмт хэргийн зөрчлийн гол шалтгааныг та юу гэж үздэг вэ?
3. Гэмт хэрэг зөрчлийн байдал өмнөх онуудын мөн үеийнхтэй харьцуулахад нэмэгдэж байна уу? Буурч байна уу?
4. Яагаад вэ?
5. Хувиараа алт олборлогчидтой холбоотойгоор гэмт хэрэг зөрчлийн гаралтыг та ихсэж байна гэж боддог уу?
6. ХАМО үргэдийн дунд гэмт хэрэг зөрчил хэр их гардаг вэ? Ямар төрлийнх илүү давамгайлах хандлагатай байна вэ?
7. Гаднаас үрсэн ХАМО нар болон нутгийн үргэдийн хооронд ямар нэгэн зөрчил үүсдэг уу? Үүсдэг бол гол шалтгаан нь юу вэ?
8. Хувиараа алт олборлодог хүмүүсийн дунд гарч буй зөрчлийн дийлэнх холбогдооч нь танай сумын үргэд байдаг уу, эсвэл гаднаас үргэд байдаг уу? Та энэ талаар өөрийн санал бодлыг ярина уу.
9. Хувиараа алт олборлогч үргэдийн дунд нийгмийн ямар тулгамдсан асуудал байна вэ? /Архидалт, биеэ үнэлэлт, танхай/
10. Гарч буй хэрэг зөрчлүүдийн хэдэн хувь нь архи, согтууруулах ундаа хэрэглэсний улмаас гарсан байдаг вэ? Алт олборлогчдын архи согтууруулах ундааг худалдах, хэрэглэхтэй холбоотой ямар зохицуулалтыг хийх шаардлагатай вэ?
11. Хувиараа алт олборлогчдын хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаанаас шалтгаалан танай сумын нутагт сүүлийн жилүүдэд тохиолдсон хүний амь эрсдэх, гэмтэх зэрэг тохиолдлуудын шалтгаан, түүнээс улбаалан гарсан хохирлын талаар ярина уу? Шороонд дарагдах, агаар дутагдах зэрэгээр хүний амь нас хохирсон тохиолдолд хэрэг бүртгэлийг хаанаас гардан явуулдаг вэ? Энэ асуудлаас гарсан хохирлыг хэрхэн шийдвэрлэсэн бэ? Дахин энэ төрлийн тохиолдол гарахаас сэргийлэх талаар ямар арга хэмжээ авсан бэ?
12. Хувиараа алт олборлогч үргэд болон албан ёсоор зөвшөөрөл аван ажиллаж байгаа алтны уурхайнүүдад тэсэрч дэлбэрэх бодис, химиин хортой бодисын ашиглалттай холбоотой тавьж буй хяналтын талаар ярина уу
13. Танай суманд хувиараа алт олборлож буй үргэдийн асуудлаар сумын хууль сахиулах байгууллагаас ямар бодлого, чиглэл барьж ажилладаг вэ?
14. Хувиараа алт олборлогч үргэдэд sumaas хууль хэрэгжүүлэх, сахиулах талаар ямар тусламж, үйлчилгээг үзүүлж байгаа вэ?

Жаргалант сумын эмчтэй хийх ганцаарчилсан ярилцлага № 4

Үргэлжлэх хугацаа:

45 минут

Шаардагдах зүйл:

дуу хураагуур, тэмдэглэл хөтлөх цаас, үзэг, тэмдэглэл хөтлөлгч

Гол асуултууд:

1. Танай суманд ХАМО үргэд хэд байдаг вэ?
2. ХАМО үргэдийн дунд зонхилон тохиолдлог эрүүл мэндийн ямар асуудал байдаг вэ?
3. Тэдний дунд ямар төрлийн өвчлөл их байдаг вэ?

4. Өвчний гол шалтгааныг та юу гэж үздэг вэ?
5. Хөдөлмөрийн аюулгүй байдлаас болж сүүлийн жилүүдэд хөдөлмөрийн чадвараа алдаж, хөгжлийн бэрхшээлтэй болсон, амь насаа алдсан иргэдийн тоог он оноор нь хэлнэ үү?
6. ХАМО иргэдээс хэдэн хүн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан бэ?
7. Яаралтай дуудлага авсан тохиолдолд сумын эмнэлгийн зүгээс хэдий хугацааны дотор эмнэлгийн анхны тусламжийг үзүүлж байна вэ?
8. Эмнэлгийн тусламжийг цаг алдалгүй хүргэхэд ямар хүндэрэлүүд гардаг вэ?
9. Сумын эмнэлгийн хүн хүч, машин техникийн боломж бололцоо хангалттай байдаг уу?
10. ХАМО нарын тоо сүүлийн жилүүдэд олширч байна уу? Хэрэв тихийм бол энэ нь эмнэлгийн үйлчилгээний ачаалалд хэрхэн нөлөөлж байна вэ?
11. Энэ асуудлыг хэрхэн зохицуулах шаардлагатай гэж та боддог вэ?
12. Хувиараа алт олборлож буй эмэгтэйчүүдийн дунд эрүүл мэндийн байдал ямар байдаг вэ?
13. Эрүүл мэндийн үйлчилгээг жирэмсэн болон нялх хүүхэдтэй эмэгтэйчүүдэд хүргэхэд ямар саад бэрхшээлүүд тохиолдог вэ? Тэдний дунд тохиолдлог нийтлэг асуудлууд юу вэ?
14. Таны бодлоор хувиараа алт олборлож байгаа иргэдийн тулгамдсан асуудлыг шийдвэхийн тулд ямар үйл ажиллагааг зохион байгуулбал дээр гэж боддог вэ?
15. Хувиараа алт олборлогчдын хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаанаас шалтгаалан танай сумын нутагт сүүлийн жилүүдэд тохиолдсон хүний амь эрсдэх, гэмтэх зэрэг тохиолдлуудын шалтгаан, түүнээс улбаалан гарсан хохирлын талаар ярина уу? Шороонд дарагдах, агаар дутагдах зэрэгээр хүний амь нас хохирсон тохиолдолд хэрэг бүртгэлийг хаанаас гардан явуулдаг вэ? Энэ асуудлаас гарсан хохирлыг хэрхэн шийдвэрлэсэн бэ? Дахин энэ төрлийн тохиолдол гарахаас сэргийлэх талаар ямар арга хэмжээ авсан бэ?

Жаргалант сумын байгаль орчны байцаагчтай хийх ганцаарчилсан ярилцлага №5

Үргэлжлэх хугацаа:

45 минут

Шаардагдах зүйл:

дүү хураагуур, тэмдэглэл хөтлөх цаас, үзэг,
тэмдэглэл Хөтлөлгч

Гол асуултууд:

Сумын засаг даргын тамгын газраас алт олборлогчдод үзүүлэх нийгмийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа

1. Танай суманд хэдэн ХАМО иргэд байдаг вэ? Өөр ямар аймаг сумдаас хүмүүс ирж алт олборлодог вэ?
2. Танай суманд хэдэн газар иргэд хувиараа алт олборлож байна вэ?
3. Хэдэн га газар ХАМО нарын нөхөрлөлд албан ёсоор алт олборлуулахаар өгөгдсөн байгаа вэ?
4. Хэдэн га газар хайгуулын лицензийтэй байна вэ?
5. Хэдэн га газарт олборлоптын лицензийтэй байна вэ?
6. Хэдэн уурхай өнөөдрийн байдлаар үйл ажиллагаага явуулж байна вэ?
7. Хувиараа алт олборлож байгаа иргэдийн орон нутгийн эдийн засгийн хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг та хэрхэн үнэлэх вэ?
8. Хувиараа алт олборлож буй иргэдээс шалтгаалан сумын байгаль орчинд ямар сөрөг нөлөөллүүд учирч байна вэ?
9. ХАМО нарын байгаль орчинд учруулж буй сөрөг нөлөөллийг том компанийтай харьцуулахад их үү бага уу?
10. Том компаний олборлосон газраас хэдий хувьд нь нөхөн сэргээлт хийгээд байана вэ?
11. ХАМО нарын олборлосон газраас хэдий хувьд нь нөхөн сэргээлт хийгээд байна вэ?
12. ХАМО нар нөхөн сэргээлт хэрхэн яаж хийдэг вэ? Нөхөн сэргээлт хийсэн газрын хэмжээг та тусад нь хэлж өгнө үү?
13. Хувиараа алт олборлох үйл ажиллагаанаас суманд орж байгаа жилийн орлогыг та юу гэж боддог вэ? Тэгвэл мал аж ахуйгаас жилд хэдэн төгрөгийн орлого олдог вэ?
14. Танай суманд хувиараа алт олборлож буй иргэдийн асуудлаар та ямар чиглэл барьж ажилладаг вэ?
15. Хувиараа алт олборлогчдын хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааг сайжруулахад сумын захиргаанаас оролцох боломжийн талаар ярина уу?
16. Танай сумын үндсэн иргэд ба гаднаас ирж алт олборлож байгаа хүмүүсийн

хоорондын харилцааг зохицуулахад сумын захиргаанаас ямар арга хэмжээ авах нь зүйтэй гэж та бодож байна вэ?

17. Орон нутгийн байгаль орчны байцаагч нар гар аргаар алт олборлогчдын үйл ажиллагаанд хяналт тавьж, тэдний байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгахад ямар эрх, үүрэгтэй оролцдог вэ?
 18. Хувиараа алт олборлогчдын үйл ажиллагаанаас байгаль орчинд учрах сөрөг нөлөөллийг багасгах талаар тэдэнд зориулж танай байгууллагаас явуулсан мэдээлэл, сургалтын талаар ярьж өгнө үү?
 19. Танай сумын нутагт хувиараа алт олборлож буй хүмүүс мөнгөн ус болон бусад химиийн хортой бодисыг хэрэглэснээс болж сумын байгаль орчинд сөрөг нөлөө үүсч байна уу?

Жаргалант сумын дэлгүүрийн эзэдтэй хийх ганцаарчилсан ярилцлага № 6

Үргэлжлэх хугацаа:

30 минут

Шаардагдах зүйл:

дуу хураагуур, тэмдэглэл хөтлөх цаас, узэг, тэмдэглэл хөтлөгч

Гол асуулттууд:

- Хувиараа алт олборлодог иргэдийн талаар та хэр сайн мэдэх вэ?
 - Жаргалант сумын иргэдийн худалдан авах чадварыг та ямар гэж үнэлэх вэ?
 - Хэрэв нууц биш бол 1 сард хэдэн төгрөгний цэвэр ашиг олдог вэ?
 - Хамгийн их худалдан авалт хийдэг хүмүүсийг нэрлэ гэвэл та ямар ажил хийдэг хүнийг хэлэх вэ?
 - Алтны гаралт, ХАМО иргэдийн тоо таны бизнест нөлөөлдөг гэж та үздэг үү? Хэдэн хувь?
 - ХАМО иргэд таниас зээлээр бараа материал авах тохиолдол байдаг уу?
 - Өнгөрсөн жилүүдтэй харьцуулахад ХАМО олширч байна уу? Цөөрч байна уу?
 - Та үүнийг ямар шалтгаанаас болж байна гэж үздэг вэ?
 - Таны бодлоор энд оршин сууж буй иргэдийн худалдан авах чадвар ямар байдаг вэ
 - Энд амьдарч байгаа иргэд бэлэн мөнгөөр шууд худалдан авалт хийдэг үү эсвэл ямар нэгэн зүйлээ барьцаанд тавьж худалдаж авдаг уу
 - Ямар төрлийн бараа илүү их зарагддаг вэ? Жилийн аль улиралд гэдгийг тодруулна уу?
 - Гол хэрэглэгчид нь ямар хүмүүс байдаг вэ?
 - Ямар төрлийн ажил эрхэлж буй иргэдийн худалдан авах чадвар өндөр байдаг вэ? Яагаад ?

Жаргалант сум дахь алтны уурхайн удирдах ажилтантай хийх ганцаарчилсан ярилцлага №7

Үргэлжлэх хугацаа:

30 минут

Шаардагдах зүйл:

дуу хураагуур, тэмдэглэл хөтлөх цаас, үзэг, тэмдэглэл хөтлөгч

Гол асунгартыңд:

1. Хувиараа алт олборлогчидтой танай уурхай ямар хэлбэрээр хамтарч ажилладаг вэ?
 2. Хувиараа алт олборлож буй үргэдээс танай уурхайд ямар бэрхшээл учирч байна вэ? Ямар тохиолдлууд гардаг талаар та бидэнд тодорхой жишээ татаж ярина уу?
 3. Хувиараа алт олборлогчдын дунд үүсч буй үргэд хоорондын харилцааны бэрхшээлээс болж танай уурхайн ажилд хүндэрэл учирдаг уу? Хэрэв тийм бол та энэ талаар тодорхой ярина уу.
 4. Хувиараа алт олборлогчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг сайжруулах талаар ямар арга хэмжээ авах нь зүйтэй вэ?
 5. Шаардлагатай тохиолдолд хувиараа алт олборлогчдод хамгаалалтын болон бусад тусламжийг танай уурхайгаас үзүүлэх боломжийн талаар та юу гэж боддог вэ?
 6. Хувиараа алт олборлогчид алтыг цэвэршигүүлэх үйл ажиллагаандaa ашигладаг мөнгөн ус, усаар угаах гэх зэрэг аргын талаар таны бодол ямар байдаг вэ?
 7. Хувиараа алт олборлогчид нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж, орон нутгийн удирдлагаас тодорхой хэмжээний газарт олборлолт хийх зөвшөөрөлтэй ажиллах бол танай уурхайгаас тэднийг мэргэжлийн зүгээс зөвлөгөө өгөх зэргээр хамтарч ажиллах боломжтой юу?

- Нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж ажиллахад орон нутагт болон танай байгууллагад тэдний зүгээс хүндрэл бэрхшээл учрах уу?
 - Хувиараа алт олборлогчдын үйл ажиллагааг зохицуулж буй дүрэм, журмыг боловсронгуй болгох талаар та ямар санал бодолтой байна вэ?

Баянхонгор аймгийн мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчтай хийх ганцаарчилсан ярилцлага № 8

Үргэлжлэх хугацаа: Шаардагдах зүйл:

45 минут

дуу хураагуур, тэмдэглэл хөтлөх цаас, узэг, тэмдэглэл хөтлөлгч

Гол асуулттууд:

Аймгийн мэргэжлийн хяналтын байгууллагаас алт олборлогчдод үзүүлж буй мэргэжлийн тусламж, үйлчилгээ

1. Танай аймагт хувиараа алт олборлож буй иргэдийн хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны асуудлаар мэргэжлийн хяналтын газраас ямар бодлого, чиглэл барьж ажилладаг вэ?
 2. Хувиараа алт олборлогчдын хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаанд гардаг нийтлэг зөрчлүүдийн талаар ярина уу? Эдгээр зөрчлийг арилгахын тулд ямар арга хэмжээг танай байгууллагаас авдаг вэ?
 3. Хувиараа алт олборлогчдын хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны талаар баримттайж ямар хууль, журам байдаг вэ? Тэдгээрийн хэрэгжилт болон мониторингийн үнэлгээний талаар ярина уу?
 4. Нөхөрлөлийн гишүүдийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаарх сургалтыг орон нутгийн удирдлагаас явуулах боломжтой юу? Тэдний хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны мэдлэг, дадлыг үнэлэх, өдөр тутмын хэрэгжилтэд хяналт тавих талаар та ямар саналтай байдаг вэ?
 5. Хувиараа алт олборлогчдын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэлд тавьдаг шаардлагын талаар ярина уу? Тэдний хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн хангалт, хэрэглээний түвшингийн талаархи хяналт, мониторингийн үр дүнгийн талаар танилцуулна уу?

Алт олборлогчдын зүгээс орон нутагт учруулж буй дарамт бэрхшээл

6. Хувиараа алт олборлогчдын зүгээс танай аймагт хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зөрчлөөс болж учруулж буй хүндэрэлийг ямар аргаар бууруулж болох вэ? Энэ талаар танай байгууллагын зүгээс юу хийх боломжтой вэ?

Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг хуулиар зохицууллах тухай

7. Хувиараа алт олборлогчид нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж, сумын засаг дарга тухайн нөхөрлөлтэй гэрээ байгуулан ажиллаж, нөхөрлөлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд хэрхэн хяналт тавьж ажиллаж болох вэ?

8. Тэдний хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг дээшлүүлэхийн тулд сум орон нутгийн удирдлагыг хэрхэн татан оролцуулж болох вэ?

9. Хувиараа алт олборлогчдын хөдөлмөрийн нөхцлийг сайжруулахын тулд аймаг, орон нутгийн удирдлагуудад ямар бэрхшээлтэй асуудал гардаг вэ?

10. Хувиараа алт олборлогчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулахын тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай гэж та бодож байна вэ?

Хувиараа алт олборлогч иргэнтэй хийх ганцаарчилсан ярилцлага №9

Үргэлжлэх хугацаа: Шаардагдах зүйл:

45 минут

дүү хураагуур, тэмдэглэл хөтлөх цаас, үзэг, тэмдэглэл хөтлөгч

Гол асүүлтүүд:

Амьдралын нөхцөл, орлого

1. Энд ажиллаж буй хүмүүс ихэвчлэн бэлэн хоол, лаазалсан бүтээгдэхүүн хэрэглэдэг гэж үнэн үү? Хэрэв үнэн бол тэдний эрүүл мэндэд үүнээс болж сөрөг нөлөөлөл гарч байгаа талаар та мэдэх үү?
2. Та олсон орлогоо хуриимтуулах, хадгалах, нэмэгдүүлэхэд ямар боломж байна гэж боддог вэ? Энэ талаар ямар арга хэмжээг алт олборлогчид болон төрийн зүгээс авах шаардлагатай вэ?
3. Таны энд амьдарч байгаа ахуйн нөхцлийг та юу гэж үнэлэх вэ? Ахуйн нөхцлөө сайжруулахын тулд алт олборлогч иргэд болон төрийн байгууллагаас ямар арга хэмжээ авах нь зүйтэй гэж та бодож байна вэ? Та энэ тал дээр хувийн зүгээс юу хийж чадах вэ?
4. Гар аргаар алт олборлосноос таны амьдралд ямар зэрэг үр дүн гарч байна вэ?
5. Гар аргаар алт олборлосноос таны амьдралд ямар сөрөг үр дүн гарч байна вэ?
6. Та яагаад гараар алт олборлох ажлыг сонгон авсан бэ? Өөр ямар нэг өрхийн орлогын эх үүсвэр байгаа юу?

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн нөхцөл

7. Та гар аргаар алт олборлоходоо хөдөлмөр аюулгүй ажиллагааны ямар журам, шаардлагыг хангадаг вэ?
8. Гар аргаар алт олборлогчдод хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлийг хангах талаар ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?
9. Алт олборлоход ажиллаж буй хүүхдийн хөдөлмөрийг хөнгөвчлөх, хүүхдийн эрхийг хамгаалах, нийгмийн туссламж, халамж үйлчилгээнд хамруулах талаар та ямар бодолтой байдаг вэ?
10. Гар аргаар алт олборлогсдын дунд ихэвчлэн ямар төрлийн осол гэмтэл гардаг вэ? Осол гэмтэл гарах үед хүмүүс согтууруулах ундаа хэрэглэсэн байдаг тохиолдол олон байдаг уу?
11. Таныг энд ажилласнаас хойш ямар осол гарч, алт олборлогчидод ямар хохирол гарч байсан бэ? Та энэ талаар ярина уу?
12. Гар аргаар алт олборлоход хөдөлмөрийн аюулгүй байдлыг дээшилгээлэх ямар боломж байна гэж та боддог вэ?
13. Та гар аргаар алт олборлож байсан эхний саруудад таньд тохиолдож байсан хамгийн бэрхшээлтэй асуудлууд болон та тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн талаараа ярина уу
14. Та алт олборлохоор анх ирээд хуучин ажиллаж байсан хүмүүстэй харилцахад учирч байсан дарамтуудын талаар ярина уу
15. Энд ажиллаж буй хүмүүсээс гэмт хэрэгт холбогдох тохиолдол их байдаг уу?
16. Энд ажиллаж буй хүмүүс дотор гэмт хэргийн улмаас ял эдэлж байсан хүмүүс хэр олон байдаг вэ? Тэднээс иргэдийг дарамтлах явдал тохиолддог уу? Та тэднээс айж цэрвэдэг үү?
17. Таны нутгийн аялга, соёл, ёс заншилтай холбоотой бэрхшээл байсан уу
18. Энд хүмүүст шинэ хоч, нэр өгөх тохиолдол их байдаг уу? Та өөрөө хочтой юу? Хэрэв хочтой бол та үүндээ эмзэглэдэг үү?
19. Та энэ ажлыг эрхэлж байгаадаа эмзэглэж байсан тохиолдол бий юу?

Амьдралын нөхцөл

Нийгмийн суурь туссламж

20. Таныг энд ирснээсээ хойш нийгмийн халамжийн ямар туссламж, үйлчилгээнд хамруулсан бэ? Алт олборлогч иргэдийн нийгмийн халамжийн туссламжийн хүртээмжтэй болгох ямар арга зам байгаа вэ?
21. Гар аргаар алт олборлож буй иргэдэд ямар төрлийн даатгалууд хэрэгтэй вэ? Та энэ талаархи өөрийн санал, бодлыг хэлнэ үү? Таньтай цуг ажиллаж буй иргэдээс ямар нэг төрлийн даатгалд даатгуулах хүсэлтэй хүмүүс бий юу? Тэд ямар төрлийн даатгалд даатгуулах хүсэлтэй байгаа вэ?
22. Та гар аргаар алт олборлогчдод үзүүлэх эмнэлгийн туссламжийн хүртээмж, цаг хугацаанд нь үзүүлэхийн тулд алт олборлогч иргэн болон төрийн зүгээс юу хийж шаардлагатай гэж бодож байна вэ?
23. Эмнэлгийн туссламжийг цаг хугацаанд нь аөч чадаагүйгээс болоод хүн нас барах, эрүүл мэндээр хохирох зэрэг тохиолдол гарч байсан уу?

24. Гар аргаар алт олборлогчдод үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн бусад тусламж, үйлчилгээний хуртээмж, чанарыг нэмэгдүүлэх арга замын талаар өөрийн санаа, бодлоо илэрхийлнэ үү?

Нөхөн сэргээлт

25. Тухайн сумын нутгийн бэлчээр, усны хэвийн байдалд учруулж буй дарамтыг бууруулахын тулд гар аргаар алт олборлогчид өөрсдийн зүгээс юу хийвэл зүйтэй гэж та бодож байна вэ?
 26. Гар аргаар алт олборлогчид нэхэн сэргээлт хийх хүсэлтэй байдаг ч тэдний өөрсдийн хүчин чадал дутах ямар асуудал байдаг вэ? Тэдэнд энэ тал дээр төрийн зүгээс ямар дэмжлэг хэрэгтэй байна вэ?

Жаргалант суманд үйл ажиллагаа явуулж буй ХААН болон Монгол Шуудан банкны удирдлагатай хийх ярилцлага №10

Үргэлжлэх хугацаа: Шаардагдах зүйл:

*30 минут
дуу хураагуур, тэмдэглэл хөтмөх цаас, үзэг, тэмдэглэл
хөтпэгч*

Гол асуултууд:

- Хувиараа алт олборлодог иргэдийн талаар та хэр сайн мэдэх вэ?
 - ХАМО иргэд танай банкаар хэр их үйлчлүүлдэг вэ?
 - ХАМО нар ямар төрлийн үйлчилгээгээр илүү үлтийлүүлдэг вэ
 - ХАМО иргэд нийт хадгаламж зээмшигч иргэдийн хэд орчим хувь байдаг вэ?
 - ХАМО иргэд хэддүгээр саруудад хадгаламжaa нэмэгдүүлж хэддүгээр саруудад буцаан татдаг вэ
 - ХАМО иргэд ямар төрлийн зээл илүү их авдаг вэ?
 - ХАМО иргэд нийт зээлдэгчдийн хэд орчим хувь байдаг вэ?
 - Тэд зээл авахдаа ихэвчлэн ямар төрлийн хөрөнгөө банкны барьцаанд тавьдаг вэ?
 - ХАМО иргэд хамгийн дээд болон доод тал нь хэдэн төграгний зээл ямар хугацаатай аедаг вэ?
 - ХАМО иргэдийн зээлийн эргэн төлөлт нь бусад зээлдэгч нарын эргэн төлөлттэй харьцуулахад ямар үзүүлэлттэй байдаг вэ?

“Байдрагийн Хөгжил”ТББ-ын удирдагатай хийх ярилцлага

Үргэлжлэх хугацаа: Шаардагдах зүйл:

*30 минут
дуу хураагуур, тэмдэглэл хөтмөх цаас, үзэг, тэмдэглэл
хөтпэгч*

Гол асүүлтүүд:

1. Танай байгууллагын гол зорилго юу вэ
 2. Зорилгоо биелүүлэхийн тулд ямар ямар үйл ажиллагаа явуулдаг вэ
 3. ХАМО иргэдийн эрх ашигийн төлөөх хийж байгаа ажлуудыг нэрлэнэ үү
 4. ХАМО иргэдийн дунд нийтлэг тохиолддог ямар асуудлууд байдаг вэ ?
 5. Асууудлуудыг шийдэхийн тулд та бүхэн сүм орон нутгийн засаг захиргаатай хэрхэн хамтран ажилладаг вэ
 6. Танай байгууллагын зүгээс дэвшүлж буй асуудлуудыг засаг захиргаа тань хэрхэн хүлээж авдаг вэ
 7. Таны бодлоор ХАМО иргэдийн нийгмийн оролцоо хэр зэрэг гэж үнэлдэг вэ?/Сайн, дунд, муу/
 8. Одоогийн байдлаар хэдэн нөхөрлөл байна вэ? Эдгээр нөхөрлөлүүд танай байгууллагатай хэрхэн яаж хамтарч ажилладаг вэ
 9. Танай байгууллагын зүгээс гишүүдэдээ зориулсан ямар үйл ажиллагаа зохион байгуулдаг вэ

10. Танай байгууллагын үйл ажиллагаанд нөхөрлөлүүд болон гишүүд дэжигчид хэрхэн оролцдог вэ, хэрхэн, яаж оролцосой гэж та хүсдэг вэ?
11. Байгууллагын удирдлагын зүгээс ХАМО цргэдийнг нэгдсэн нэг зохион байгуулалтанд оруулж тэдний эрх ашигийн төлөө ажиллахад ямар хүндэрэл бэрхшээлүүд гардаг вэ?
12. Танай байгууллагын цаашдын зорилго ву байна вэ?
13. ХАМО цргэдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, гэгээрүүлэхэдта бүхний зүгээс ямар мэдлэг, чадвар дутуагддаг вэ нэрлэнэ үү?

ХАВСРАЛТ 7

Статистик үзүүлэлтүүд		Аймаг	Сум
		2008	2008
Нийт хүн амын тоо		82 205	3 049
	эр	40 116	1 512
	эм	42 089	1 537
	0-5	9 132	326
	эр	4 592	155
	эм	4 540	171
	6-18	23 958	810
	эр	12 127	401
	эм	11 831	409
	19-25	12 948	485
	эр	6 461	260
	эм	6 487	225
	26-35	13 680	533
	эр	6 642	256
	эм	7 038	277
	36-45	10 368	421
	эр	5 013	203

ЭМ	5 355	218
46-55	6 261	240
эр	2 862	120
ЭМ	3 399	120
56-65	3 029	131
эр	1 306	58
ЭМ	1 723	73
65<	2 829	119
эр	1 097	49
ЭМ	1 732	70
Хөдөлмөрийн насны иргэдийн тоо	51 309	1 961
Эр	-	897
ЭМ	-	840
Ажил хөдөлмөр өхрэлж буй хүний тоо/хөдөлмөрийн насны/	-	81,8 %
Хөдөлмөр эрхэлдэг хүний тоо	40053	/78%
Ажил хөдөлмөр эрхлээгүй хүний тоо		136
ХАА н салбарт	64 %	
Уул уурхайн салбарт	42%	
Жаргалант сумын татварын орлого, төсвийн гүйцэтгэл		3984 600/ 132.9 %
АА нэгж, байг ууллагын ажилчдын сарын дундаж цалин		257 400
Уул уурхайн салбарт ажиллаж байгаа ажилчдын сарын дундаж цалин		160 000
Нийт өрхийн тоо	22 412	852
1-4 ам бүлтэй өрхийн тоо	-	-
5-10 ам бүлтэй өрхийн тоо	-	-
10< ам бүлтэй өрхийн тоо	-	-
Өрх толгойлсон эмэгтэй	3 036	52
Хагас өнчин хүүхдийн тоо	1 925	38
Бүтэн өнчин хүүхдийн тоо	185	5
Ажил эрхлэгчдийн тоо	40 053	1475
Эр	20 594	787
ЭМ	19 459	688
Ямар ажил хөдөлмөр эрхэлдэг болох	-	
Төрийн албан хаагч	-	70
Төрийн бус байгууллагад ажиллагсад	-	12
Хувираа бизнес эрхлэгчид	-	24
Хувийн компанийд ажиллагсад	-	2
Малчин	-	637
Алт олборлодог	-	730
Идэвхтэй ажил хайгч	2 299	-
Ажилгүй иргэдийн тоо	2 892	-
Нийт ХАМО иргэдийн тоо		500
Тогтмол алт олборлодог ХАМО нар		200

Амьжиргааны баталгаажих доод түвшнээс доогуур амьдралтай өрхийн тоо. Үүнээс;	9 133	-
* Нэн ядуу	3 308	
Амьжиргааны түвшний доод хэмжээ	89 000	89 000
Сургуулийн тоо	30	1
Дунд сургууль	15	1
12 жилийн сургууль	11	-
Нийт сургуулийн багтаамж	-	-
Нийт сургуулиудад одоо суралцаж байгаа хүүхдийн тоо	18 844	635
1-6 ангийн хүүхдийн тоо	9 796	270
7-10 ангийн хүүхдийн тоо	6 982	231
11-12 ангийн хүүхдийн тоо	2 086	134
Сургууль завсардсан хүүхдийн тоо	2	0
Нийт эмнэлгийн тоо	27	1
Больниц	-	1
Амбультори	-	1
Нийт их эмчийн тоо	123	3
Бага эмчийн тоо	-	3
Сувилагч	-	6
Асрагч	-	5
Нийт малын тоо	2 643,5	110 595
Хонь	705,2	42 884
Ямаа	1 696,9	42 205
Үхэр	122,4	18 438
Тэмээ	27,4	11
Адуу	916	7 057
Аймаг, сум багийн хэмжээнд гарсан хэрэг зөрчил	349	
Аймаг	196	-
Сум	12	-